



МОНГОЛЫН ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал

Судалгааны тайлан

Талархал

Энэхүү судалгаа нь Монголд хүний эрхийг хамгаалагчдын талаар явуулж буй анхны судалгааны ажил бөгөөд судалгаагаар хүний эрхийг хамгаалагч гэдэг ойлголтын талаар авч үзэн, хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг нийтлэг бэрхшээл, нөлөөлж буй хүчин зүйлс, бэрхшээлийг шийдвэрлэх боломжийг тодорхойлох оролдлого хийсэн юм.

Энэхүү тайлан, судалгааны үр дүн нь хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалахад төрийн болон төрийн бус байгууллага, оролцогч талууд хамтран ажиллахад оруулж байгаа нэгээхэн хувь нэмэр болно.

Судалгааг Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас санхүүжүүлж судалгааны багийн гишүүд хийж гүйцэтгэв. Судалгааг судалгааны нэгжид амжилттай зохион байгуулах, тайланг боловсруулахад судалгааны багийн гишүүд идэвхи зүтгэл гарган ажиллав.

Судалгааны ажлыг явуулах, тайланг боловсруулахад үнэтэй дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монголын Эмнести Интернэшнл байгууллагын хамт олонд гүн талархлаа илэрхийлье.

Эцэст нь судалгааг анхан шатны нэгжид зохион байгуулахад шаардлагатай мэдээ материалаар хангаж, дэмжлэг үзүүлж хамтран ажилласан Төв, Дархан, Орхон Уул аймаг дахь ТББ-ын салбар зөвлөл, Улаанбаатар хотын ТББ-ын төлөөлөгч нарт болон судалгаанд хамрагдаж үнэтэй мэдээлэл өгч туслалцаа үзүүлсэн нийт оролцогчдод талархаж байгаагаа уламжилъя.

Ц. Пүрэв

Судалгааны багийн зөвлөх,
ШУА-ийн ФСЭХ-ийн Социологийн
секторийн ахлах мэргэжилтэн, доктор /Ph.D./

Товчилсон нэр томъёоны тайлбар:

ДБ	Дэлхийн Банк
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУ-ын ЗГ	Монгол улсын засгийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
УЕПГ	Улсын Ерөнхий Прокурорын Газар
ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
ҮЭ	Үйлдвэрчний Эвлэл
ХЭТТ	Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал
ХХИ	Хүний Хөгжлийн Индекс
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ЭБШХ	Эрүүгийн байцаан шийтгэх хууль

Агуулга

Талархал	i
Товчилсон нэр томъёоны тайлбар:	ii
Удиртгал. Судалгааны арга зүй, зохион байгуулалт.....	1
Үндэслэл	1
Сэдвийн судлагдсан байдал	1
Судалгааны зорилго, зорилт	2
Судалгааны арга зүй, аргачлал	2
Судалгааны хамрах хүрээ	3
Цаг хугацааны нөлөөлөл	4
Судалгааны явцад гарсан хүндрэл бэрхшээл	4
Тайлангийн бүтэц	5
Бүлэг 1. Монгол улс дахь хүний эрхийн хамгаалалт	6
1.1 Төрийн тогтолцоо ба хүний эрхийн хамгаалалт	6
1.2 Иргэний нийгмийн институт ба хүний эрхийн хамгаалалт	7
1.3 Эдийн засаг, нийгмийн хүчин зүйлс ба хүний эрхийн хамгаалалт	7
1.4 Хүний эрхийн төлөв байдал Монголд	9
Бүлэг 2. Хүний эрхийг хамгаалагчид.....	11
2.1 Хүний эрхийг хамгаалагч гэж хэн бэ?	11
2.2 Хүний эрхийг хамгаалагчид юу хийдэг вэ?	12
2.3 Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах шаардлага	13
2.4 Монголд хүний эрхийг хамгаалагчдын тухай ойлголт	14
Бүлэг 3. Монголд хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээл	18
3.1 Хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээл	18
3.2 Хүний эрхийн ТББ-ын ажилтнуудад тулгардаг бэрхшээл	19
3.3 ҮЭ-ийн байгууллагад ажиллагсдад тулгардаг бэрхшээл	22
3.4 Хуульч, өмгөөлөгчдөд тулгардаг бэрхшээл	24
Бүлэг 4. Бэрхшээлийг шийдвэрлэх боломж, арга зам.....	29
4.1 Хүний эрхийн ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг	29
4.2 ҮЭ-ийн ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг	30
4.3 Хуульч, өмгөөлөгч эмэгтэйчүүдийн Фокус бүлэг	31
Дүгнэлт, бодлогын зөвлөмж	33
Хавсралтууд	36
Хавсралт А. Урьдчилсан судалгаанд уулзалт зохион байгуулсан Төрийн болон ТББ-ын жагсаалт	36
Хавсралт В. Фокус бүлэг, ганцаарчилсан сурвалжлагын аргаар судалгаа явуулах арга зүйн удирдамж	37
Хавсралт С. Судалгааны багийн гишүүд	40
Ашигласан материал.....	41

Удиртгал. Судалгааны арга зүй, зохион байгуулалт

Үндэслэл

“Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал” судалгааны тайланд “. . . Бүхэлд нь үзвэл Монгол улсад хүний үндсэн эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээний түвшинд өргөмжилсөн хэдий ч түүнийг хангах нийгэм эдийн засгийн нөхцөл, эрх зүйн орчин олигтой бүрэлдэж хараахан амжаагүй байгаа билээ. Ялангуяа хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн хэм хэмжээг амьдралд хэрэгжүүлэх шатанд багагүй бэрхшээлүүд учирч цөөнгүй зөрчил гарч байгаа нь нууц биш юм” гэж дүгнэжээ [УБ 2001. хуудас 135].

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжүүлэх явцад гарч байгаа тэдгээр зөрчлийг бууруулахын тулд хууль сахиулагчдад нөлөөлөх, эрх нь зөрчигдсөн иргэдийн эрх ашгийг хамгаалахад хүний эрхийг хамгаалагчдын үүрэг, оролцоо ихээхэн чухал болно.

Монгол улсын бүх шатны шүүхийн байгууллагад ажиллагсдын /шүүгчдийн/ 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн ҮЭ, ТББ-д /хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг/ ажиллагсдын дунд эзлэх эмэгтэйчүүдийн хувь чамгүй өндөр юм.

Өнгөрсөн жилүүдэд Монгол улсад хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах талаар маш бага анхаарч ирлээ. Иймээс олон улсын хүний эрхийн Эмнести Интернэшнл байгууллагын “Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалцгаая” кампанит аян, мөн дээр өгүүлсэн нөхцөл байдлаас үүдээд “Монголд хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийг хамгаалах боломж” сэдэвт судалгааны ажлыг Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас хэрэгжүүлж буй “Эргэх Холбоо” төслийн хүрээнд гүйцэтгэв.

Сэдвийн судлагдсан байдал

Судалгааны сэдвийн хүрээнд багийн гишүүд урьд өмнө энэ чиглэлээр хийгдсэн болон хийгдэж буй ажлуудын талаар холбогдох хүмүүстэй уулзалт ярилцлага зохион байгуулах, баримт бичиг, материалыг судлах замаар сэдвийн судлагдсан байдлыг тодруулсан билээ.

Монгол улсад урьд өмнө энэ чиглэлээр ямар нэг судалгааны ажлууд төдийлөн хийгдэж байгаагүй бөгөөд багийн гишүүд энэ чиглэлийн

судалгааны ажлыг хараахан олж үзээгүй болно. ХЭҮК-оос гаргасан судалгааны тайлан, илтгэлд хүний эрхийн зөрчлүүд хууль эрх зүйн зохицуулалт, заалтуудын хэрэгжилтийн талаар илүүтэй авч үзсэн байв. Мөн уулзалт ярилцлагад оролцогч хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид “. . . урьд өмнө судлагдаж байгаагүй сэдэв, хийгдсэн тодорхой ажлууд бараг байхгүй, судлах шаардлагатай тулгамдсан сэдэв болохыг” онцлон тэмдэглэж байсан юм.

Харин олон улсын түвшинд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахад ихээхэн анхаарах болсон бөгөөд, зарим улс орнуудад хийгдсэн судалгааны ажлуудыг багийн гишүүд анхааран судалсан болно.

Судалгааны зорилго, зорилт

Зорилго: Хүний эрхийг хамгаалах, иргэний нийгмийг төлөвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагад хүний эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагаанд оролцогч /ялангуяа хуульч, өмгөөлөгч, ТББ, ҮЭ-д ажиллагч/ эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах шаардлага, өнөөгийн нөхцөл, гадаад дотоод орчны нөлөөллийг тодруулахад судалгааны ажил чиглэж байв.

Зорилтууд: **нэгд**; сэдвийн судлагдсан байдал, өнөөгийн нөхцөл байдлыг тодруулах, сэдвийн онцлог шинжийг харгалзан үзэж судалгааны арга зүй, аргачлалыг нарийвчлан боловсруулах үүднээс “Нөхцөл байдлын урьдчилсан судалгаа”-г явуулав, **хоёрт**; судалгааны бэлтгэл ажлыг хангаж анхдагч мэдээллийг цуглуулахад ихээхэн ач холбогдол өгөв, **гуравт**; судалгааны ажлыг судалгааны нэгжид зохион явуулах, үр дүнг боловсруулахад анхааран ажиллав.

Судалгааны арга зүй, аргачлал

Сэдвийн судлагдсан байдал, онцлог шинжийг харгалзан үзээд судалгааг Чанарын судалгааны арга зүйд тулгуурлан Фокус бүлгийн хэлэлцүүлэг болон Ганцаарчилсан сурвалжлагын аргыг хослуулан ашиглах замаар анхдагч мэдээллийг цуглуулсан болно.

- **Фокус бүлгийн аргаар:** 8–10 хүртэлх гишүүнтэй хуульчдын, өмгөөлөгчдийн, ТББ, ҮЭ-д ажиллагсдын болон холимог бүлгүүдийг зохион байгуулж хэлэлцүүлгийн сэдвийн хүрээнд бүлэгт чөлөөт ярилцлага өрнүүлэх замаар тэдэнд тулгардаг асуудлууд, хүндрэл

бэрхшээлийг судлав. Үүний тулд оролцооны арга зүйд тулгуурлан бүлгийн гишүүдээр тодорхойлуулан эрэмбэлүүлсэн болно.

- **Ганцаарчилсан сурвалжлагын аргаар:** бүлгийн хэлэлцүүлэгт дурьдагдсан тодорхой тохиолдлуудыг илүү нарийвчлах, дэлгэрэнгүй тайлбарлуулахад чиглэсэн тусгайлсан уулзалт ярилцлагыг зохион байгуулсан болно.

Судалгаагаар цугларсан мэдээллийг Чанарын судалгааны мэдээллийг боловсруулах аргачлалын дагуу боловсруулав. Мэдээллийг нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх явдал судлаачдаас чамгүй цаг хугацаа, хүч хөдөлмөр, дадлага туршлага шаардаж байв.

Судалгааны хамрах хүрээ

Судалгааг орон нутаг, нийслэлд зохион явуулахаар ажлын даалгаварт тусгагдсаны дагуу судалгааны баг дараах байдлаар хамрах хүрээг тогтоов /дараах хүснэгтээс харна уу/.

Хүснэгт 1. Судалгааны хамрах хүрээ байршил, арга зүйн ялгаатай байдлаар

Байршлаар	Судалгааны арга зүйгээр	
	Фокус бүлгийн хэлэлцүүлэг	Ганцаарчилсан сурвалжлага
Багануур дүүрэг	- ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг /12 гишүүнтэй/	2 оролцогчтой ганцаарчилсан ярилцлага зохион байгуулав
Төв аймаг	- ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг /6 гишүүнтэй/	
Дархан Уул аймаг	- Хуульч, ТББ болон ҮЭ-ийн ажилтан эмэгтэйчүүдийн холимог Фокус бүлэг /9 гишүүнтэй/	1 оролцогчтой ганцаарчилсан ярилцлага зохион байгуулав
Орхон Уул аймаг	- Хуульч эмэгтэйчүүдийн Фокус бүлэг /8 гишүүнтэй/ - ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг /6 гишүүнтэй/	1 оролцогчтой ганцаарчилсан ярилцлага зохион байгуулав
Улаанбаатар хот	- Өмгөөлөгч эмэгтэйчүүдийн Фокус бүлэг /6 гишүүнтэй/ - Хуульч оюутан залуучуудын Фокус бүлэг /12 гишүүнтэй/ - Үйлдвэрчний эвлэлийн ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг /15 гишүүнтэй/	2 оролцогчтой ганцаарчилсан ярилцлага зохион байгуулав

Судалгааны хамрах хүрээг, “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тусгагдсан Төвийн бүсийн хүн ам төвлөрсөн суурин газрын төлөөллийг хангахуйц байхаар сонгон судалгааны анхдагч нэгжийг үүсгэв. Чанарын судалгааны арга зүйн хувьд хангалттай хэмжээний төлөөлөл хэмээн үзсэн болно. Судалгааны нэгжүүдийн нийт хүн ам /1 сая 147.5 мянга¹/, хотжилт, эдийн засгийн чадамж, өөр хооронд нь харьцуулах боломжийг харгалзан үзэв.

“Нөхцөл байдлын урьдчилсан судалгаа”-ны явцад холбогдох албан тушаалтнууд, ТББ-ын удирдах ажилтнуудтай уулзалт ярилцлага зохион байгуулсан юм [Хавсралт-А хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү].

Цаг хугацааны нөлөөлөл

Өргөн хүрээнд авч үзвэл, Монгол улсын Засгийн газар “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал үндэсний хөтөлбөр”, “Мянганы хөгжлийн зорилт”, “Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг” зэрэг төсөл хөтөлбөрүүдэд тусгагдсан зорилт, хүлээгдэж буй үр дүнд хүрэх нь чухал болов. Үүний тулд хүний эрхийг бодитоор хангаж, нийгэм дахь баялгийн тэгш бус хуваарилалт, нийгмийн бүлгүүдийн дундах зааг ялгааг мэдэгдэхүйц багасган эрх зүйн тогтолцоог улам төгөлдөржүүлэхэд оруулах хүний эрхийг хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлж, хүчтэй болгоход энэхүү тайлангийн ач холбогдол оршино.

Нөгөө талаас, хүний эрхийг хамгаалагчдын эрх, тэднийг хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулсаных нь төлөө үзүүлж болох гадаад дотоод орчны нөлөөлөл, сөрөг хандлагаас хамгаалах талаар өнөөг хүртэл дорвитой ажил хийгдээгүй байна. Энэ үүднээс хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах чиглэлд оруулах энэхүү судалгааны ажлын нөлөө, цаг хугацааны хүчин зүйлийг чухалчилан үзэж байна.

Судалгааны явцад гарсан хүндрэл бэрхшээл

Судалгааны ажил чанарын судалгааны арга зүйд суурилсан учраас үүнтэй холбоотой арга зүй, аргачлалын шинжтэй хүндрэлүүд тулгарч байсан ч судалгааны ажлын чамгүй туршлагатай зөвлөгч, багийн гишүүдийн хүчин чармайлтаар хүндрэлийг даван туулав. Түүнчлэн цаг хугацааны хувьд шахуу байсан нь үйл ажиллагаагаа нарийн төлөвлөх, ихээхэн хүч, цаг зарцуулахыг багийн гишүүдээс шаардаж байв.

¹ ҮСГ-ийн 2003 оны статистикийн эмхтгэлд тулгуурласан тооцоолол.

Судалгааны баг үйл ажиллагаагаа 2004 оны 10 дугаар сарын дунд үеэс эхэлж 2005 оны 2 дугаар сарын сүүлч хүртэлх хугацаанд явуулав.

Тайлангийн бүтэц

Судалгааны тайлан удиртгал үндсэн дөрвөн бүлэг, дүгнэлт зөвлөмжөөс бүрдэх бөгөөд хавсралт болон ном зүйн хэсгээс бүрдэж байгаа болно. Удиртгал хэсэгт судалгааны зорилго, хамрах хүрээ, судалгааны арга зүйн талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, судалгааны үйл явцын тухай өгүүлсэн болно.

Нэгдүгээр бүлэгт; Монгол улс дахь хүний эрхийн өнөөгийн төлөв байдлыг хууль эрх зүй, хүний эрхийг хамгаалах бүтэц тогтолцоо, эдийн засаг нийгмийн хүчин зүйлийн хандлагаар илүүтэй тайлбарлан авч үзэхийг хичээсэн болно.

Хоёрдугаар бүлэгт; хүний эрх, хүний эрхийг хамгаалагч, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах талаар судалгааны үр дүнг нэгтгэн оролцогсод хэрхэн ойлгож, хандаж байгааг харуулахыг зорьсон.

Гуравдугаар бүлэгт; судалгаанд оролцогсод хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулахад нь ямар хүндрэл бэрхшээл тулгардаг, тэдэнтэй хэрхэн ханддаг талаар судалгааны үр дүн болон бусад улс орнуудын жишээ баримтанд тулгуурлан авч үзэв.

Дөрөвдүгээр бүлэгт; хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх боломж, арга замуудыг судалгаанд оролцогсод хэрхэн үзэж байгаа, эн тэргүүнд ямар зүйлд илүү анхаарах хэрэгтэй гэж үздэгийг судалгааны үр дүнд тулгуурлан авч үзсэн болно.

Эцэст нь судалгаагаар гарсан үр дүнгүүдийг багцлан илэрхийлэх замаар Монголд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах боломж, арга замуудын талаар нэгтгэсэн дүгнэлт, бодлогын зөвлөмжийг өгөв.

Бүлэг 1. Монгол улс дахь хүний эрхийн хамгаалалт

Энэ бүлгийн агуулгын дор Монгол улсын төрийн тогтолцоо, хүний эрхийн төлөв байдал, иргэний нийгмийн институт, эдийн засаг нийгмийн хүчин зүйлсийг хүний эрхийг хамгаалах хамгаалалт болох талаас нь тоймлон авч үзэв.

1.1 Төрийн тогтолцоо ба хүний эрхийн хамгаалалт

Монгол улс 1992 онд анхдугаар шинэ Үндсэн хуулиа батлан тунхаглаж “Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх”-ийг эрхэм зорилго болгосноор Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас Зах зээлийн эдийн засгийн харилцаанд, Социалист системээс Ардчилсан засаглалд шилжих үйл явц өрнөсөн юм.

Монгол улсад төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал байхаар шинэ Үндсэн хуулинд заасан байна. Бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгуулиар ард түмэн өөрсдийн төлөөлөгчдийг УИХ-д сонгох бөгөөд УИХ нь 76 суудалтай. Монгол улс нь засаг захиргааны зохион байгуулалтын хувьд нийслэл хот, 21 аймаг тэдгээрийн нэгж болох сум дүүрэг, баг хорооноос бүрдэнэ.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх үндсэн зарчим баримтлан ажиллахаар хуульчилан заасан байдаг.

Өнөөдөр улс төр, нийгэм эдийн засгийн шинэ тогтолцооны үндсэн институцууд бүрдсэн байна. Шинэ Үндсэн хуулинд тусгагдсан томоохон ололт нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн үндсэн зарчмыг тодорхойлж эрх мэдлийн хэмжээг тодорхойлж өгсөнд оршино. Үндсэн хуулийн дөрөв дэх хэсгийн 49.1-д “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана” гэж заасан нь “шударга шүүхээр шүүгдэх, шүүхийн өмнө хүн бүр ижил тэгш байх” гэсэн хүний үндсэн эрхийг баталгаажуулахад чухал хүчин зүйл болно.

1.2 Иргэний нийгмийн институт ба хүний эрхийн хамгаалалт

Ардчилсан тогтолцоонд шилжсэнтэй зэрэгцээд Монгол улсад иргэний нийгмийн тухай ойлголт хүчтэй болж иргэний нийгмийн институт болох төрийн бус байгууллагууд олноор төрөн гарсан билээ. Тэдгээрийн дотроос хүний эрхийг хамгаалах чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг ХЗДХЯ-нд бүртгэлтэй 100² гаруй төрийн бус байгууллага байна.

Тэдгээрт “Монголын Өмгөөлөгчдийн холбоо”, “Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо”, “Глоб Интернэшнл”, “Олон улсын Эмнести Интернэшнл байгууллагын Монгол дахь салбар”, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”, “Хуульч эмэгтэйчүүдийн холбоо”, “Хүний эрх ба Хөгжил төв”, “CEDAW Watch төв” гэх мэт ТББ-ыг дурьдаж болно. Түүнчлэн эрх зүйн туслалцаа үзүүлдэг Хууль зүйн товчоод, Нотариат, Арбитрийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд олноор бий болов³. Үүний зэрэгцээ салбар бүрийн ҮЭ, холбоод нь хөдөлмөрийн харилцаанд үүсч болох маргаан, хүний эрхийн зөрчлийг хянах, ажиллагсдын эрхийг хамгаалахад чухал үүрэгтэй юм.

Хүний эрхийг баталгаатай хангах, зөрчигдөхөөс сэргийлэхэд иргэний нийгмийн институцийн гүйцэтгэх үүрэг чамгүй билээ. Өнөөдөр Монгол улсад нэгэнт хэлбэржин бий болсон иргэний нийгмийн бүрдэл хэсэг болох төрийн бус байгууллагууд (ялангуяа хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг) төрийн институцууд, засаг захиргааны нэгж, албан тушаалтнуудад нөлөөлөх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, хамтран ажиллах чиглэлд ихээхэн зүйл хийж багагүй үр дүнд хүрэв.

Гэсэн хэдий ч ихэнх ТББ-уудын чадавх сул /санхүү, төрийн дэмжлэг, уялдаа холбоо/, тэдний идэвхитэй үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг хандлага байсаар байгаа нь албан тушаалтан, эрх мэдэлтний өмнө хүчин мөхөсдөх үндэс болсоор байна.

1.3 Эдийн засаг, нийгмийн хүчин зүйлс ба хүний эрхийн хамгаалалт

Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр Пост-Социалист улс орнуудын нэгэн адил хүндрэл бэрхшээлтэй тулгарч байв.

Өнөөдөр эдийн засгийн гол үзүүлэлт болох Монгол улсын ДНБ-ний өсөлт 2003 онд 5.6%-д хүрсэн нь хүрвэл зохих түвшингийн доод хязгаар

² Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал. УБ 2001. хуудас [133].

³ Илүү дэлгэрэнгүйг . . . “Монгол улсын хуулийн байгууллага, хуульчдын лавлах товчоо, Эрх чөлөө төв, УБ 2003.”-оос үзнэ үү.

бөгөөд өмнөх жилүүдийн өсөлт үүнээс доогуур түвшинд байгаа юм. Харин 2004 онд 10.6%-д хүрсэн нь дэлхийн зах зээл дахь Монгол улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн тааламжтай орчин бий болсонтой холбоотой.

Хамгийн сүүлд хийгдсэн “Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний түүвэр судалгаа 2002/03”-гаар Монгол улсад ядуурлын хамрах хүрээ 36.1%, хүн амын дундах хэрэглээний ялгааны индекс 0.329 болсныг тодорхойлжээ.

Дэлхийн банкнаас гаргасан “Дэлхийн хөгжлийн үзүүлэлт”-д дурьдсанаар Монгол улсын албан ёсны зээл тусламжийн хэмжээ 208 сая ам.долларт хүрсэн бол харин нэг хүнд ногдох ДНБ-ээр 166-д, хүн амын худалдан авах чадвараар 167-р байранд байгааг харж болно⁴.

Монголд орлогын болон өмчийн тэгш бус байдал, ялгаа зааг ихэссээр байгаа нь хүн амын дундах ядуурал, ажилгүйдэл хүрээ хязгаараа улам бүр тэлж байгааг харуулж байна [“Кит Гриффин, Монгол дахь ядуурлыг бууруулах стратеги”-иас илүү дэлгэрүүлэн үзнэ үү]. Ядуурлыг дагасан сөрөг үзэгдлүүд нийгэмд хүчтэй илрэх болов. Ялангуяа ядууралд өртсөн, нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх явдал анхаарал татсан асуудал болоод байна.

1999 он хүртэл Монгол улсын Хүний Хөгжлийн Индекс 1990 оны түвшингээс ахиж чадсангүй. Харин сүүлийн жилүүдэд түүний хандлага сайжирсаар байна. . . .2003 оны дэлхийн “Хүний хөгжлийн илтгэл”-д Монгол улс ХХИ-ээрээ нийт 175 орноос 117 дугаар байранд оржээ [“Монголын Хүний Хөгжлийн Илтгэл”-ээс илүү дэлгэрэнгүй үзнэ үү].

Үүний зэрэгцээ шилжилтийн жилүүдэд гэмт хэргийн тоо бараг хоёр дахин өссөн нь ядуурал, маргаашдаа үл итгэх явдал нэмэгдсэнтэй холбоотой юм. Хувь хүний баталгаагүй байдал /гэмт халдлагад өртөх, эрх зөрчигдөх/ өсөн нэмэгдэхийн хирээр иргэд хуулийн хамгааллыг тэгш хүртэх явдал иргэдийн эдийн засгийн боломж, хууль сахиулах байгууллагуудын чадамж, орон зайн болон хүртээмжийн тэгш бус байдлыг ямар түвшинд хүртэл багасгасан эсэхээс шалтгаалах болно. Эрүүл мэнд, боловсролын салбарт ч энэ байдал ажиглагдсан хэвээр байна [Монголын Хүний Хөгжлийн Илтгэл, хуудас – /18-19/].

Хувь хүний эдийн засгийн эрхийн хамгаалалт хангалтгүй байгаа нь ихээхэн анхаарал татсан асуудал болж байна.

⁴ Статистикийн эмхтгэл – 2003, УСГ, УБ 2004. Бүлэг 23, хуудас [301-329].

1.4 Хүний эрхийн төлөв байдал Монголд

Монгол улсын шинэ Үндсэн хуулийн 2-р бүлэгт хүний эрхийн асуудлыг онцгойлон авч үзэн Хүний эрх, Эрх чөлөөг хуульчилан зааж өгсөн нь Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц дэлхий нийтийн жишигт хүрсэн алхам болсон байна. Түүнчлэн Монгол улс 1961 онд НҮБ-ын гишүүнээр элсэн орж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын /ХЭТТ/ үзэл санааг дэмжиж улмаар хүний Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад 1974 онд нэгдэн орсноос хойш хүний эрхийн талаарх 30 гаруй гэрээ, конвенц, протоколд нэгдэн орсон буюу соёрхон баталсан болно⁵.

Шүүх тогтолцоо, хүний эрхийн төрөлжсөн байгууллагууд (Эмнести Интернэшнл, Хүний эрх хөгжил төв, ҮЭ, холбоод гэх мэт) мөн иргэний нийгмийн байгууллагууд, төр, иргэдийн оролцоогүйгээр хүний эрх зөрчигдөхөөс бодитоор хамгаалах боломж хязгаарлагдмал юм. Монгол улсын УИХ “Хүний эрхийн үндэсний комиссын тухай” хуулийг 2000 онд баталснаар олон улсын гэрээ конвенц, Монгол улсын хууль, тогтоомжийн биелэлтэд хүний эрхийн чиглэлээр хяналт тавьж, судлан дүгнэх үүрэгтэй үндэсний байгууллага болох Хүний Эрхийн Үндэсний Комисс 2001 онд байгуулагдав. Түүнчлэн захиргааны хэргийг хянан шийдвэрлэх шүүх тогтолцоо 2004 оноос бий болов.

Монгол улсын Засгийн газраас олон улсын хэмжээнд хүлээсэн үүргээ биелүүлж НҮБ-ын Хүний эрхийн хороо болон төрөлжсөн байгууллагуудад 10-аад удаа өөрийн орны ажлын тайланг хэлэлцүүлээд байна.

Шигтгээ 1: НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн хороо болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос гаргасан зөвлөмжинд:

. . . Нийгэмд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, ялангуяа улс төрийн амьдралд оролцох оролцоо тэдний мэдлэг, чадвараас үл хамааран доошилсон; шүүхийн хараат бус байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлэхүйц хүчин зүйлсийг багасгах; шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхэд шаардагдах хэвийн нөхцлийг хангах; хүний эрх нь зөрчигдсөн хохирогчдын гомдлыг барагдуулах талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлж, хохиролгүй болгож чадахгүй байгаа; нийгмийн хамгааллын арга хэмжээ нь ядуурлын тархалт, хэмжээг хязгаарлахад үр нөлөө багатай байгааг дурьдсан байна . . .

Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал, УБ 2001. хуудас [11].

⁵ Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал, УБ 2001 он. хуудас [11].

Шигтгээ 2:

“ . . . Монгол улсад иргэн хувь хүн эрх, эрх чөлөөгөө эдлэх хууль зүйн нааштай орчин аажмаар бүрэлдэж, нийгмийн ухамсарт хүний эрхийн шинэ ойлголт нэвтрэн төлөвшиж байна; Үүний зэрэгцээ, Хүний эрхэд халдах, хөндөх, хүрээ зааг үндэслэлийг зөвхөн хуулиар тогтоох асуудалд дутуу дулимаг хандаж, зарим талаар гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үзэмжийн асуудал болгон орхигдуулдгаас Үндсэн хуулийн үзэл санаанд харшилсан хэм хэмжээ, тогтоол, шийдвэр гарган мөрдүүлэх явдал үзэгдсээр байна, . . . Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа нь иргэнд үйлчлэх үйлчилгээний чиг үүргээсээ захиран тушаах, албадах хандлага хуучин зуршлаас салаагүй, хүнд суртал, чирэгдэл гаргах эрх мэдлээ хэтрүүлэх, хууль илт зөрчих зэргээр хүний эрхийг гажуудуулах үзэгдэл нийтлэг ажиглагдав; Шүүх, прокурорын байгууллагын хараат бус байдлыг нь сайжруулах, боловсон хүчний чадавхийг ихээр нэмэгдүүлэх шаардлагатай байна; Хувийн эрх, эрх чөлөөний хувьд иргэний халдашгүй байх эрхийг цагдаа, хүчний байгууллагаас ноцтой зөрчих явдал түгээмэл байгаа нь бусад хувийн эрхтэй харьцуулахад хамгийн доод түвшинд байна”.

Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал. УБ 2001. хуудас [131-135]

Хүний эрхийг хангах чиглэлээр хууль эрх зүйн хангалттай тогтолцоо нэгэнт бүрдсэн хэдий ч хүний эрх зөрчигдөх, зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлд төдийлөн үр дүнд хүрч чадахгүй байх явдал байсаар байна.

Шигтгээ 3:

“ . . . Шүүх эрх мэдлийн хүрээн дэх хүний эрхийн зөрчлийг арилгахад хуулийн байгууллагуудын тогтолцоо, ажилтнуудын ажил дүгнэх журам, үнэлгээг эргэж хянан үзэхийг амьдрал шаардаж байна, . . . Хууль тогтоомжид хүний эрхийг нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын жишиг, стандартад нийцүүлэн тусгах талаар цаашдаа их анхаарах ёстой. Шинэ ЭБШХ-д /хуулийн 58-р зүйл/, цагдан хорьж мөрдөх хугацаа /24-30 сар/, насанд хүрээгүй этгээдийг баривчлах ба цагдан хорих хугацаа /18 сар/ болон бусад зарим заалтыг хууль тогтоогчийн зүгээс эргэн харж, авч үзэх шаардлагатай байгаа юм.”

Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. ХЭҮК, УБ 2003 он. хуудас [84]

Хүний эрхийг хуульчилан баталгаажуулах, хангах үйл явцад оролцогч талуудын авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, хүрсэн үр дүн, хүндрэл бэрхшээлийг дээр өгүүлсэн бүгдээс тоймлон харж болох юм. Өнөөг хүртэл авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь ихэнхдээ хүний эрхийг хангах, баталгаажуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлд түлхүү анхаарч байснаас бус хүний эрхийг хамгаалах үйл явцад оролцогч хүний эрхийг хамгаалагчдын зөрчигдсөн эрхийг хамгаалах, тэндий эрхийг баталгаажуулахад тэр бүр анхаарч байсангүй.

Бүлэг 2. Хүний эрхийг хамгаалагчид

Энэ бүлэгт хүний эрхийг хамгаалах болон хүний эрхийг хамгаалагчдын талаарх ойлголтыг судалгаанд оролцогсод хэрхэн үзэж байгааг судалгааны үр дүн, эрх зүйн тайлбартай уялдуулан авч үзсэн болно.

2.1 Хүний эрхийг хамгаалагч гэж хэн бэ

Дэлхий нийтийн хэмжээнд хүний үндсэн эрх, эрх чөлөөг сахин хамгаалахад баримталж буй нийтлэг баримт бичиг нь “Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал” /1948 онд батлагдсан/, “Хүний эрхийн олон улсын Билль” бөгөөд түүнээс салбарлан гарсан олон тооны гэрээ конвенцоос бүрдэж байна. Улс орон бүр өөрийн орны иргэдийн өмнө, бусад улс орны өмнө тэдгээр нийтлэг дүрэм журмаар тодорхой үүрэг хүлээж байдаг.

Харин тодорхой ойлголтуудын талаар одоо авч үзье. “Олон улсын хүний эрхийн нэр томъёоны тайлбар толь”-д **Хүний эрхийг хамгаалах** гэдэг ойлголтыг доорх байдлаар тайлбарласан байна.

Хүний эрхийг хамгаалах (Protection of Human Rights)

. . .Энэ нь хүний эрхийг зөрчихөөс хамгаалах явдал юм. Хохирогч болж болзошгүй этгээдийн эрх зөрчигдөх явдлаас хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор төр болон хувь хүн, хүмүүс, байгууллага болон улсуудын хоорондын харилцаанд идэвхитэй хөндлөнгөөс оролцох ёстой.

. . .Хүний эрхийн хэм хэмжээний хүрээнд хүний эрхийг зөрчсөн явдал гаргахгүй байх талаар позитив⁶ үүрэг хүлээж төрөөс холбогдох арга хэмжээ авахад оршино. Хэрэв тухайн улс гүрэн энэ үүргээ биелүүлж чадахгүй бол олон улсын хэм хэмжээ болон хэрэгжүүлэх тогтолцоо /"нэмэлт"/ хамгаалалтын хэрэгсэл болдог.

Дээрх тайлбараар хүний эрхийг хамгаалах гэдэг нь маш өргөн хүрээтэй, оролцогч талуудыг хамрах хүрээ хязгаарлагдмал бус юм. Нэг талаас өөрийн эрх, эрх чөлөөгөө хамгаалахад тухайн хувь хүн, байгууллага, үндэстэн, улс гүрэн идэвхитэй оролцох ёстой. Харин нөгөө талаас оролцоо нь хязгаарлагдмал, хүчин мөхөс байгаа тохиолдолд хөндлөнгийн оролцогчид оролцож болно. Тэдгээр хөндлөнгийн оролцогчдыг хүний эрхийг хамгаалагчид гэж нэрлэж болно. Тайлбар тольд авч үзсэнээр **Хүний эрхийг хамгаалагч** гэдэг нь;

⁶ Позитив үүрэг – Төрөөс тодорхой үйлдэл хийхийг шаардсан эрх зүйн үүрэг юм. Тухайлбал, алан хядах үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үзүүлэх зэрэг хүний эрхийн асуудлыг зохицуулсан хэм хэмжээний дагуу төрөөс хэрэгжүүлэхийг шаардах үүрэг.

Хүний эрхийг хамгаалагч (Human Rights Defenders)

. . . Нарийн судлуулж, арга хэмжээ авахуулах үүднээс гарч байгаа болон гарч болзошгүй хүний эрхийн зөрчлийн талаар гол төлөв хүний эрхийн байгууллагад мэдээлэл дамжуулах замаар хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулж байгаа хүн, бүлэг этгээд, байгууллага /ТББ/-ыг хэлнэ. Тэднийг хүний эрхийг хамгаалагч, хүний эрхийн төлөө тэмцэгч, хүний эрхийн зүтгэлтнүүд, зохион байгуулагчид гэх мэтээр янз бүрээр нэрлэдэг.

Олон олон хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийн хууль ёсны хэм хэмжээг хүндэтгэн хариуцлагатай ажиллаж байна.

2.2 Хүний эрхийг хамгаалагчид юу хийдэг вэ?

Хүний эрхийн төлөө тэмцэгч хамгаалагч нь хүний амьд явах салшгүй эрхүүд болох ялгаварлан гадуурхахгүй байх, чөлөөтэй эвлэлдэн нэгдэх, боловсрол эзэмших эрх, нэр төртэй буюу адил тэгш байх, зохистой орон байраар хангагдах, эрүүл байх, ундны цэвэр ус буюу хүрэлцээтэй хоол хүнсээр хангагдах зэрэг эрхийг дэмжин хамгаалахад идэвхитэй ажилладаг. Тэд зарим үед тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн тухайлбал, эмэгтэйчүүд, хүүхэд, уугуул иргэд, үндэсний цөөнхийн эрх, дүрвэгсдийн болон дотооддоо шилжин суурьшигч, цагаачлагч иргэдийн эрхийг хамгаалахад анхаарлаа хандуулдаг.

Хүний эрхийг хамгаалагч нь хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн асуудлаар илтгэл, тайлан бэлтгэх, мэдээлэл цуглуулах буюу мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг. Ихэвчлэн тэдний олж цуглуулан боловсруулан, тайланд тусгагдсан эдгээр ажлууд нь хүний эрхийн хүний эрхийн байгууллагуудаар дамжуулагдан олон нийтэд хүрдэг. Гэсэн хэдий ч зарим хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийн ямар нэгэн ноцтой зөрчлийн талаархи мэдээллийг хувь хүмүүсээс цуглуулдаг.

Хүний эрхийг хамгаалагчид зүтгэлтэнүүдийн үйл ажиллагааны хамгийн гол шалгуур нь хүний эрхийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үйл ажиллагаагаар нь ангилна. Хүчирхийллийн асуудлаар тайлан гаргах болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь хүний эрхийн хүчирхийллийн хохирогчдын хэргийг хууль, шүүхээр шийдүүлэх, хүчирхийлэл үйлдэгчдийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн үргэлжилэх хугацааг төгсгөл болгоход тусалж чадна. Зарим хүний эрхийн тэмцэгчид шүүхийн үйл ажилгаанд хохирогчдыг төлөөлөн оролцдог. Мөн тахир дутуу

иргэдийг дэмжих хамгаалах болон хохирогчидод зөвлөгч, өмгөөлөгч нь болдог. Тэд хүний эрхийн асуудлаар засгийн газарт үйл ажиллагааны тайлангаа хэвлүүлэн илгээдэг бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд тусалдаг.

2.3 Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах шаардлага

Хүний эрхийн зөрчлийн талаар мэдээлэл дамжуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулсныхаа төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтанд өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүнийх нь эрх зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол өнөөдөр дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна.

Жил бүр олон зуун сэтгүүлчид, өмгөөлөгчид, ҮЭ-ийн гишүүд зэрэг хүний эрхийг хамгаалагчид хүний эрхийг хамгаалах үйл явцад оролцсоныхоо төлөө хүчирхийлэл дарамтанд ямар нэг байдлаар өртсөн тоо мэдээ, жишээ баримт олныг дурьдаж болно. Ийм тохиолдлууд дэлхий нийтийн халуун цэгүүд, хүний эрхийг зөрчиж буй улс орнуудад илүү олон, харгис шинжтэй байгаа төдийгүй ардчилсан улс орнуудад ч цөөнгүй гарсаар байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж байгаа хүний эрхийг хамгаалагчдын тэмцэл олон улсын ялангуяа НҮБ-ын холбогдох байгууллагуудын анхааралд өртөх боллоо. НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газраас 1998 онд “Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай тунхаглал”-ыг баталсан. Тунхаглалын 12 дугаар зүйлд;

- Хүн болгонд эрх байдаг бөгөөд хувь хүн, байгууллага, бүлгүүд ч хүчирхийллийн эсрэг, энх тайвны үйл ажиллагаа, эрх, эрх чөлөөний төлөө хувь нэмрээ оруулдаг байх хэрэгтэй.
- Улс орон бүр өөрсдийн хууль тогтоомжиндоо хүний эрхийг хамгаалах талаар тусгах хэрэгтэй.
- Энэ харилцаанд хүн бүхэн оролцох бөгөөд хувь хүн, байгууллага, бүлгүүд үндэснийхээ хуулинд тусгаж хамгаалж байх ёстой гэж заажээ.

Мэдээж хүн бүр хүний эрхийг хамгаалах нь ямар чухал болох талаар олон шалтгааныг дурьдаж чадна. Гэхдээ хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах талаар өнөөг хүртэл хийж байгаа алхмууд, хамгаалалтын механизм нь олон улсын хүний эрхийн төрөлжсөн байгууллагууд, холбоодын

хэмжээнээс тэр бүр хэтэрч гарсангүй. Засгийн газар тэднийг хамгаалах баталгаа гаргах, аюулгүй байдлыг нь хангах онцгой арга хэмжээ авах шаардлагатай юм.

Шигтгээ 4. Хүний эрхийн ажилтанг шоронд хорьжээ

Сирийн Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хорооны тэргүүн 53 настай Актим Нуяса 2004 оны 4 дүгээр сарын 13-нд баривчлагджээ. Хүний эрхийн зөрчлийн тухай илтгэлийг ХЭАЭЧХХороо хэвлэн нийтэлсэн, онц байдал тогтоосныг зогсоох кампанит ажлыг удирдан зохион байгуулсных нь төлөө түүнийг баривчилжээ. Эмнести Интернэшнл түүнийг үзэл санааны хоригдол, Сири улс нь Олон улсын хүний эрхийн тухай хуулинд заасан үүргээ зөрчин хууль бусаар баривчилсан хэмээн үзэж байна. Түүний өмгөөлөгчийнх нь мэдэгдсэнээр “социалист системийн эсрэг үйл ажиллагаа явуулсан”, “хувьсгалын эсэргүүцсэн хэмээн” Улсын дээд шүүх яллаж 15 жилийн хорих ял оноожээ.

Эх сурвалж: The Wire, Amnesty International.

Шигтгээ 5. Малайз: Хүний эрхийн төлөө тэмцэгч шоронд хоригджээ

Тенаганита эмэгтэйчүүдийн ТББ-ын тэргүүн Ирене Фернандсийг 1996 онд хорих лагериас суллагдсан Филиппин, Индонез, Бангладеш улсын иргэд голдуу 300 гаруй хүнээс авсан ярилцлагадаа тулгуурлан хорих лагерийн нөхцлийн талаар мэдээлэл нийтлүүлснийх нь төлөө хуурамч мэдээлэл нийтлүүлсэн хэргээр хорьсон байна. Давж заалдах шатанд барьцаагаар суллагдсан боловч олон улсын хүний эрхийн ямарваа хурал зөвлөгөөнд оролцохыг нь хориглосон байна. Хорих байрны нөхцлийг судлан, шүүмжлэлийг хүлээн авахын оронд тэр талаар судлахыг эрмэлзсэн Ирене Фернандсийг баривчлан хорихыг оролдож байгаад Эмнести Интернэшнл харамсаж байна.

Эх сурвалж: The Wire, Amnesty International.

Эдгээр жишээ баримтыг олон нийт тухайн үедээ буруушааж үзэх боловч идэвхитэй тэмцэх, тэмцэлд нэгдэн оролцох нь хязгаарлагдмал байгаагаас тэр бүр хүний эрхийг зөрчигсдөд хүчтэй нөлөө үзүүлж чадахгүй байна. Магадгүй оролцоо хязгаарлагдмал байхад тухайн улс орон дахь нийгмийн байгуулал, засаглалын хэв шинж, соёлын онцлог, сэтгэл зүйн хүчин зүйлс нөлөөлж байгаа боловч тэдгээр хүчин зүйлсэд баригдахгүй байх нь хамгаас чухал юм.

2.4 Монголд хүний эрхийг хамгаалагчдын тухай ойлголт

“Хүний эрхийг хамгаалагч” гэдэг ойлголтыг хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн байгууллагын төлөөлөгчид, оролцогсод хэрхэн ойлгож байгааг тодруулах үүднээс “Хүний эрхийг хамгаалах гэдгийг та

хэрхэн ойлгож байна вэ? Хүний эрхийг хамгаалагч гэж хэнийг хэлэх вэ?” гэсэн асуултуудад хариулт авсан юм.

Уулзалт ярилцлагад оролцсон 15 оролцогчдын дээрх асуултанд өгсөн хариултыг дараах байдлаар бүлэглэв. Оролцогсад хүний эрхийг хамгаалах гэдгийг;

- Хэм хэмжээг зөрчихгүй байхад анхаарал хандуулах, зөрчигдсэн тохиолдолд сэргээх,
- Эрх нь зөрчигдсэн тохиолдолд хуулийн дагуу хамгаалах,
- Эрх нь зөрчигдсэн хүмүүсийн эрхийг хамгаалахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх явдал гэсэн байдлаар тайлбарласан байна.

Харин хүний эрхийг хамгаалагч гэдгийг;

- Хүний зөрчигдсэн эрхийг хамгаалах, эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлж буй хүмүүс,
- Хүний эрхийг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд,
- Хуульд заасан чиглэлээр хүний эрхийг хамгаалах чиглэлээр цогц үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийг хэлнэ гэж үзжээ.

Харин Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогсад эдгээр ойлголтыг дараах байдлаар ойлгож байв.

Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлгийн гишүүд хүний эрхийг хамгаалагч гэдгийг;

- Эрх нь зөрчигдөж байгаа хүнд туслах, зөвлөгөө өгөх талаар ажиллаж байгаа ТББ-ын хүмүүс,
- Хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй байгууллагууд,
- Төрөөс гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийн төлөө төрийн болон ТББ-д ажиллаж буй хүмүүс,
- Шагнал цалин, ямар нэгэн даатгалд хамрагдаж чаддаггүй, нийгмийн халамж хамгаалал байхгүй, өөрсдийн авъяас чадвар, хүсэл эрмэлзлэлээр ажиллаж байгаа хүмүүс,
- Шударга ёсны төлөө явж байгаа хүмүүсийг хэлнэ гэж тайлбарласан байна.

ҮЭ-ийн ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлгийн гишүүд хүний эрхийг хамгаалагч гэдгийг;

- Хүний эрхийн талаар гаргасан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэгч, албан тушаалтан, албан хаагчдыг хэлнэ,
- Хүний эрхийн төрийн болон ТББ-д ажиллаж байгаа хүмүүсийг хууль эрх зүйн талаар хамгаалагчийг хэлнэ,
- Бусдын эрхт халдахгүйгээр өөрийн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийг хэлнэ гэж үзсэн байна.

Дээрх тайлбар, ойлголтууд нь өөр хоорондоо агуулгын хувьд нэг боловч Фокус бүлгийн гишүүдийн эрхэлж буй ажил мэргэжил, үйл ажиллагааны ялгаатай байдлаас үүдэн хандсан байв. Өөрөөр хэлбэл ҮЭ-ийн гишүүд нь сонгуульт ажилтан байдаг, ажил олгогч болон ажилтан хоорондын хөдөлмөрийн маргаан, аливаа зөрчилд хөндлөнгөөс оролцож ажилтны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Харин ТББ-ын⁷ ажилтнууд нь тухайн ТББ-ын санхүүгийн чадавх, үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбон тайлбарласан байв. Нөгөө талаас хүний эрхийн зөрчил гарахаас сэргийлэх, эрх нь зөрчигдсөн хүмүүст зөвлөгөө өгөх, хүний эрхийг хамгаалахад гуравдахь ч этгээд болон хөндлөнгөөс оролцож байгаа хүмүүс, байгууллага болох талаар дээрх Фокус бүлгүүдийн тайлбаруудад ижилхэн дурьдагдсан байна. Эдгээр тайлбарлал, ойлголт нь тайлбар тольд дурьдсан ойлголттой агуулгын хувьд ойролцоо бөгөөд энд төдийлөн зөрүүтэй хандлага ажиглагдаагүй юм.

Түүнчлэн энэ ойлголт хуульч эмэгтэйчүүдийн Фокус бүлэгт хэрхэн хөндөгдсөнийг дараах хэсгээс харья. Үүнд,:

- Хуульч, өмгөөлөгч, хууль хяналтын байгууллагын ажилтнууд,
- Хүний эрхийн зөрчлийн эсрэг тэмцэж байгаа хүмүүс, төр орно,
- Хүний эрхийн чиглэлээр ажилладаг ТББ-ыг оруулж болно,
- Эрхээ хамгаалуулахаар тэмцэж байгаа хүмүүс, хүүхэд хүртэл орно,
- Мөн сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг оруулж болно гэсэн нэлээд өргөн хэмжээтэй тодорхойлолтыг өгсөн байна.

⁷ Цаашид ТББ-ын ажилтан гэдгийг Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын ажилтан гэж ойлгох. Энд нийгмийн бүх чиглэлээр ажиллаж байгаа ТББ-ын ажилтнуудыг нийтэд нь хамаатуулж үзээгүй болно.



Судлаачид Фокус бүлгийн гишүүдийн дунд асуудлыг хэлэлцүүлж буй байдал /2004 оны 11-р сар/

Фокус бүлгийн гишүүд энэхүү тодорхойлолтоороо хүний эрхийг хамгаалахад оролцогч талуудын хамрах хүрээг бүхий л түвшинд авч үзэж, тэдний оролцоог чухалчилсан байна. Үүнээс үзэхэд хүний эрхийг хамгаалах, хамгаалагчдыг хамгаалах тухай ойлголт оролцогсдод ямар нэг хэмжээгээр байгаа бөгөөд гагцхүү энэхүү ойлголтыг нэг мөр ойлгох,

хүний эрхийг хамгаалагч хүмүүсийн эрх ашгийг хамгаалахад онцгой ач холбогдол өгч хандах бодит шаардлага байгаа юм.

Монгол улсын хувьд хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсныхаа төлөө дарамт, хүчирхийлэлд өртсөн эрх нь зөрчигдсэн өмгөөлөгч, хуульчид, үйлдвэрчний эвлэлийн гишүүд, хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын ажилтнууд, хүний эрхийг хамгаалагчдын талаар албан ёсоор мэдээлсэн ямар нэг тоо баримт байхгүй. Энэ талаар хийгдсэн судалгааны ажил ч маш ховор юм. Гэхдээ энэ нь хүний эрхийг хамгаалагчдад бэрхшээл тулгардаггүй, эрх нь зөрчигддөггүй гэсэн үг биш юм.

Түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчин нөхцөл сайн бүрдээгүй, энэ талаар хийж буй ажил бага байгаа талаар мөн тулгамдсан чухал асуудал хөндөж байгаа тухай уулзалт ярилцлагад оролцогсод, судалгаанд хамрагдсан бүлгийн гишүүд дурьдаж байв.

Энэ талаар дараагийн бүлгүүдэд хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээл, түүнийг шийдвэрлэх боломжийн талаар судалгааны үр дүнд тулгуурлан авч үзнэ.

Бүлэг 3. Монголд хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээл

Монголд хүний эрхийг хамгаалагчдад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулахад ямар бэрхшээл тулгардаг болохыг энэ бүлэгт судалгааны үр дүнд тулгуурлан тодруулах болно.

Хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээл нь улс орон бүрт харилцан адилгүй байдлаар илэрдэг бөгөөд янз бүрийн хэлбэртэй байж болох юм. Хэдийгээр ардчилсан засаглалтай, хүний эрхийг хууль эрх зүйн хүрээнд баталгаажуулсан, хүний эрхийг дээдэлсэн улс оронд ч хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчих, дарамт үзүүлэх явдал байсаар байна.

Хамгийн чухал нь төрийн хүний эрхийг хамгаалах чухал хэрэгсэл болох засаглалын институц, хүчний байгууллага, албан тушаалтнууд хэр зэрэг нээлттэй, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж байгаад ач холбогдол өгөх хэрэгтэй.

Тухайн нийгэм, улс оронд иргэн хүн хэр зэрэг эрх чөлөөтэй ажиллаж амьдарч, шийдвэр гаргаж, үзэл бодлоо илэрхийлж, бусдаас хараат бус байж, шударга шүүхээр ялгаварлалгүй шүүгдэж байгаа эсэх нь хамгийн чухал шалгуур хүчин зүйл болно.

3.1 Хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээл

Олон улсын хэмжээнд хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг бэрхшээл, сөрөг хандлагууд нь магадгүй бидний мэдэж байгаагаас ч олон хэлбэр, төрхтэй байж болох юм. Ерөнхийд нь тэдгээр дарамт, сөрөг нөлөөллийг дараах байдлаар илэрхийлж болох юм.

Хүнд хэлбэрүүд;

- Амь насанд нь халдах, өгүүтгэх,
- Эрүүдэн шүүх, хүч хэрэглэх, зодох, хүнд гэмтэл учруулах,
- Шоронд хорих, эрх чөлөөг хасах, мөрдөж мөшгих,
- Нийгмээс тусгаарлах, үзэл бодлыг нь хавчин гадуурхах,
- Хувь хүний эрх чөлөөг хязгаарлах, эрх чөлөөнд нь бүдүүлгээр халдах,
- Байнга айлган сүрдүүлэх, заналхийлэх,

- Байнга сэтгэл зүйн дарамт үзүүлэх гэх мэт хэлбэрүүд байж болно.

Нийтлэг хэлбэрүүд;

- Ажлаас нь халах, өөрчлөх,
- Цалин болон нийгмийн халамжийг хязгаарлах, шударга бусаар хандах
- Мэдээлэл авах боломжийг нь хязгаарлах,
- Үндэслэлгүйгээр цагдан хорих, тагнах,
- Заналхийлэх, айлган сүрдүүлэх, хилс хэрэгт гүтгэх, доромжлох,
- Үйл ажиллагааг нь үгүйсгэх, дэмжихгүй байх,
- Сэтгэл зүйн дарамт үзүүлэх, ялгаварлан гадуурхаж хандах,
- Төрөл төрөгсөд, ойр дотных нь хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх,
- Үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нь хаах гэх мэт маш олон хэлбэрээр илэрдэг байж болно.

Эдгээр нь хүний эрхийг хамгаалахаар тэмцэж буй хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагаагаа хэвийн явуулахад саад учруулахуйц, нөлөө үзүүлэхүйц арга хэрэгслүүд бөгөөд тухайн эсрэг тал /хүний эрхийг зөрчигч буруутай албан тушаалтан, бүлэг этгээд, хувь хүн, төрийн зүгээс/-аас үзүүлж буй сөрөг хандлага болно.

Эдгээр сөрөг хандлагууд тэдэнд хэрхэн илэрч байгааг судалгаанд оролцсон фокус бүлгийн гишүүд /хүний эрхийн ТББ-д ажиллагсад, ҮЭ-ийн гишүүд, хуульч эмэгтэйчүүдийн/ хэрхэн үзсэнийг дараах хэсгүүдэд авч үзье.

3.2 Хүний эрхийн ТББ-ын ажилтнуудад тулгардаг бэрхшээл



Судлаачид Фокус бүлгийн гишүүдийн дунд асуудлыг хэлэлцүүлж буй байдал /2004 оны 11-р сар/

Хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд нь иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалахад чухал хамгаалалтын болоод хяналтын механизм болох учиртай. Хүний эрхийн зөрчлийг таслан зогсооход хөндлөнгийн

зүгээс оролцож олон нийтийн дэмжлэгийг авах нь хүчтэй нөлөө үзүүлэх хэрэгсэл болно.

Хэдийгээр хангалттай олон тооны фокус бүлэг зохион байгуулах хөрөнгө, цаг хугацааны боломж муу байсан ч хот хөдөөгийн 33 төлөөлөл оролцсон 4 фокус бүлэг болон уулзалт ярилцлагын явцад хөндөгдсөн асуудлуудыг хүснэгт 2-т багцлан харуулав.

Хүснэгт 2. ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээл /эрэмбээр/

Эрэмбэ	Тулгардаг бэрхшээл
I	ТББ-ыг дэмжин ажиллах төрийн байгууллагын идэвхи сул, үйл ажиллагааг ойшоодоггүй, хамтын ажиллагаа дутагддаг, үнэлж үздэггүй явдал
II	Эрхээ хамгаалах талаар эрх зүйн мэдлэг иргэдэд хомс байх явдал,
III	Үйл ажиллагаа явуулахад учирдаг санхүүгийн бэрхшээл, чадамж муу байх явдал
IV	Ажиллагсдын нийгмийн хамгаалал, цалин хөлс, амьжиргааны баталгаа хангалтгүй байх явдал
V	ТББ хоорондын хамтын ажиллагаа дутагдалтай байх явдал
VI	Хувь хүний нэр хүндэд халдах, гутаан доромжлох, заналхийлэлд өртөх, дарамтлах

Фокус бүлгийн гишүүд төрийн байгууллага, албан тушаалтнуудтай харилцахад хамгийн их бэрхшээл тулгардаг гэж үзэж байв. Энэхүү бэрхшээл нь дараах байдлаар илэрдэг гэж үзэж байлаа. Үүнд:

- Албан тушаалтнуудын зүгээс хойрго хүнд сурталтай ханддаг,
- Төрийн байгууллагаас мэдээлэл авахад бэрхшээлтэй байдаг,
- Цаг хугацаа алдах, олон дахин хүсэл тавих болдог,
- Үнэлж үздэггүй эмэгтэй хүн гэдэг утгаар энэ ч дээ гэсэн байр сууринаас ханддаг,

Эдгээр илрэлүүд нь үйл ажиллагаа явуулах, хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлдөг нийтлэг хандлага юм. Мөн бүлгийн хэлэлцүүлгийн явцад оролцогсдын зүгээс өгүүлсэн нэгэн баримтыг одоо авч үзье.

Баримт 1. ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн фокус бүлгийн хэлэлцүүлэг

. . . Хүний эрх зөрчигдөж байгаа гол шалтгаан нь төрийн байгууллагын албан хаагчид өөрсдийгөө иргэдийг захирч байх ёстой гэсэн сэтгэл зүйтэй байгаагийн улмаас хүмүүсийг гаднах байдлаар нь ялгаварлан гадуурхах, хүнд суртал гаргах зэргээр хүний эрх зөрчигдөхөд хүргэдэг. Төрийн байгууллага гэдэг иргэдэд үйлчилдэг, тэдний эрхийг хамгаалдаг үйлчилгээний байгууллага байдаг иргэд өөрсдөө ч үүнийг мэдэхгүй төрийн албан хаагчдаас айж сүрддэг, өөдөөс нь эсэргүүцэж чаддаггүй учраас төрийн байгууллагын албан тушаалтан хэт дур зоргоороо авирладаг. Үүнийг арилгахын тулд иргэдэд төр тэдэнд үйлчилдэг, тэдний эрхийг хамгаалах ёстой, иргэдээс дэмжигдэж байдаг гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Мөн төрийн албан хаагчдын ёс зүйг сайжруулах хэрэгтэй.

Эх сурвалж: Фокус бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл

Дээрх баримтад хөндөгдсөн асуудал нь бүлгийн гишүүдийн үзэл бодол бөгөөд үүнийг судлаачдын зүгээс ямар нэг шүүмж, засвар хийлгүй тайланд оруулсан болно. Бүлгийн гишүүдийн үзэж байгаагаар иргэдийн хууль эрх зүйн мэдлэг хомс, мэдээлэлгүй байгаа байдал нь төрийн албан хаагчдын хууль бус, шударга бус хандлагад хүлцэнгүй хандаж эвлэрэх, эрхээ хамгаалахаар шаардлага тавихгүй байх нэг шалтгаан болдог байна. Энэ нь хүний эрхийн ТББ-ын ажилтнуудад тулгардаг удаах томоохон бэрхшээл болдог байна.

Үүнээс гадна үйл ажиллагаагаа тогтвортой явуулах санхүүгийн боломж хязгаарлагдмал байдгаас шалтгаалж далайцтай ажил явуулж чаддаггүй, ажиллагсдынхаа нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх /ЭМД, НД-ын шимтгэл гэх мэт/ боломжгүй байдаг нь ажилтнуудын амьжиргааны баталгааг эдийн засгийн утгаар хангах бололцоо бүрдэж чаддаггүй байна. Энэ үүднээс боловсон хүчний бодлого зарим талаар алдагдаж ажилтнууд тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрддэггүй байж болох юм. Нөгөө талаар гэр бүлийн гишүүдийн зүгээс сөрөг хандлага /цалин мөнгөгүй гэх, ажлын цаггүй ажилладаг гэх мэтээр/ сэтгэл зүйн дарамт үзүүлэх шалтгаан болдог.

2003 оны байдлаар ашгийн бус байгууллагад ажиллагсдын цалингийн дундаж хэмжээ 63.8⁸ мянган төгрөг байгаа нь улсын дундаж /81.5 мянган төгрөг/ үзүүлэлтээс 22%-иар бага байна.

⁸ ҮСГ, Статистикийн эмтхгэл – 2004. хуудас [74].

Баримт 2. Нэгэн ТББ-ын ажилтан Г-тэй ярилцсан ярилцлага:

. . . Би төрийн бус байгууллагад 7 дахь жилдээ ажиллаж байна. Эхний үед мэдлэг чадвар дутмаг байдлаас болж ажиллахад бэрхшээлтэй байсан. Зарим байгууллагууд бидний үйл ажиллагааг ойлгодоггүй, бас зарим талаар хүний эрхийн асуудлыг хэр хөндөж тавина тэр хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлэх хандлага байдаг. Ер нь хэдэн хүүхнүүдийг өмөөрсөн байгууллага гэдэг үүднээс эрэгтэйчүүд хүлээж авдаг. Мөн албан тушаалтнуудын зүгээс далд хэлбэрээр сэтгэл зүйн дарамт үзүүлэх байдал ажиглагддаг. Ер нь ажиглаж байхад хүний эрхийг хөндөж тавьсан хүн эргээд ад шоо болох тал байдаг.

. . . Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгч байх үедээ хэний нөхөр намайг ирж зодох бол гэж их айдаг байсан. Энэ нь ажил мэргэжилтэйгээ холбоотой байнгын стресст орох шалтгаан болдог.

. . . Би сүүлийн 3 жил цалингүй ажиллаж байна. Нийгмийн даатгал бөглөгдөөгүй учир тэтгэвэрт гарах боломжгүй. Гэтэл одоо хүүхдүүд том болж, амьжиргаагаа залгуулах мөнгө их хэрэгтэй болсон. Эцсийн эцэст хүний эрхийн төлөө ажиллах нь өөрийн гэр оронд анхаарал тавих завгүй, амьдралын түвшин доогуур болж байна.

Эх сурвалж: Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл

Түүнчлэн ТББ хоорондын хамтын ажиллагаа сул байгаа нь үйл ажиллагаанд тулгардаг бас нэг бэрхшээл болдог байна. Бага боловч дарамт үзүүлэх, хувь хүний нэр хүндэд халдах, заналхийлэх явдал гардаг гэж бүлгийн гишүүд үзэж байгаа нь анхаарал хандуулах шаардлагатай асуудал юм.

3.3 ҮЭ-ийн байгууллагад ажиллагсдад тулгардаг бэрхшээл

Бүлгийн хэлэлцүүлэгт оролцогсад тэдэнд тулгарч байгаа бэрхшээлийг дараах байдлаар авч үзсэн байна.

Хүснэгт 3. ҮЭ-ийн ажилтан эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээл /эрэмбээр/

Эрэмбэ	Тулгардаг бэрхшээл
I	ҮЭ-ийн ажилтнууд нь сонгуулт ажилтан байдаг учир ажлын байрны баталгаагүй байдаг, ажил олгогчийн зүгээс ажилласан жил зэрэг хүчин зүйлийг чухалчилан үздэг байдал
II	Шийдвэр гаргагч захиргааны ажилтнууд хууль, хүний эрхийг ихээр зөрчдөг тэд эрх мэдэл, мөнгөтэйгээрээ далимдуулан байнга дарамтладаг явдал
III	Сэтгэл санааны дарамтанд оруулах, цалингаас хасах, нэр хүнд унагаах шууд бус хэлбэрийн бэрхшээлүүд тулгардаг явдал
IV	Ажилтнуудын эрхээ хамгаалах мэдлэг, ухамсар муугаас үйл ажиллагаа дэмжигдэхгүй байх, шантрах явдал
V	Нийгмийн баталгаа хангалтгүй байх явдал

Хүснэгтээс үзэхэд дээд шатны удирдах албан тушаалтнууд, захиргааны албан хаагчдын зүгээс ҮЭ-ийн гишүүдэд дарамт үзүүлэх, ажлын бүтээмжийг

үнэлэхдээ шударга бусаар хандах явдал нь хамгийн их бэрхшээл учруулдаг хүчин зүйлс болдог байна. Эдгээрийг илүү тодруулан илэрч байгаа хэлбэрүүдийг нь бүлгийн гишүүдийн тодорхойлсноор багцлан авч үзье. Үүнд:

- Ажлын байрны баталгаа алдагдах,
- Өө эрж цалин, нэмэгдэл, шагнал урамшууллаас хасах,
- Ажиллах нөхцөл бололцоо олгохгүй байх,
- Ажлын ачааллыг нэмэгдүүлэх,
- Сэтгэл зүйн дарамтанд оруулах,
- Аливаа байгууллагын удирдлага үл тоомсорлох, хүнд суртал гаргаж харилцах

Эдгээр нь ҮЭ-ийн ажилтнуудад тулгардаг томоохон бэрхшээлүүдийн илрэх хэлбэр бөгөөд шууд бус арга замаар, далд байдлаар дарамтлах явдал байгааг харж болно. Хэдийгээр ҮЭ-ийн гишүүдийн эрхийг ноцтой байдлаар зөрчсөн хүнд хэлбэрүүд Монголд байхгүй боловч гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ажиллагсдын эрх ашгийг ноцтой зөрчих явдал ихээр гарч байгааг зарим нэг баримтаас харж болно. Энэ явдалтай ҮЭ-ийн гишүүд хэрхэн тэмцэж байгаа, тэдэнд ямар бэрхшээл тулгарч байгааг нарийвчлан судлах нь зүйтэй юм].



Судлаачид Фокус бүлгийн гишүүдийн дунд асуудлыг хэлэлцүүлж буй байдал /2004 оны 11-р сар/

Ажиллагсдын эрхийн зөрчлийн талаар ХЭҮК-оос 2003 онд гаргасан “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл”-д тодорхой авч үзсэн бөгөөд “Хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан эрхийн хэрэгжилт” гэсэн хэсгээс дэлгэрүүлэн үзэж болно.

ҮЭ-ийн гишүүдийн эрх зөрчигдөж байгаа талаар фокус бүлгийн хэлэлцүүлэгт дурьдагдсан баримтыг авч үзье.

Баримт 3. ҮЭ-ийн ажилтан эмэгтэйчүүдийн фокус бүлгийн хэлэлцүүлэг

. . . ҮЭ-ийн удирдлагууд ярьдаг мөртлөө ажилтнуудынхаа эрхийг хамгаалдаггүй. Эрх хамгаалдаг нэртэй байгууллага нь ч өөрсдөө эрхийн зөрчил гаргадаг. Хүний эрхийг хамгаалж байна гээд л худлаа ярьдаг хүмүүс бид нар дотор ч олон байдаг.

. . . Бид энэ ажилтайгаа байхын тулд хоёр нүүр гаргах шаардлага гардаг болсон. Энэ нь өдөр өдрөөр улам л ихэсч байна. Манайд хоёр нүүр гаргасан хүн л дэвшдэг жишиг тогтоод байна.

Эх сурвалж: Фокус бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл

Харин бусад улс оронд ҮЭ-ийн гишүүдийн эрхийг зөрчиж буй зарим нэг баримтаас цухас авч үзье.

Шигтгээ 6. Беларусьт Үйлдвэрчний эвлэлийн гишүүд аюулд өртөөд байна

. . . 2003 оны 10 дугаар сард Беларусийн Авто болон хөдөө аж ахуйн машин үйлдвэрлэлийн үйлдвэрчний эвлэлийн хороо (БАХААМҮҮЭХ)-ны дарга Александр Бухвостов Минскийн төв цагдан хориход ҮЭ-ийн дотоод ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг эсэргүүцсэн тайван замаар цуглаан зохион байгуулж байгаад баривчлагджээ. Тэрээр Засгийн газраас дэмжлэг туслалцаа авдаг Беларусийн Аж Үйлдвэрийн Үйлдвэрчний Эвлэлд БАХААМҮҮЭХ-ны гишүүдийг хүчээр нэгтгэх гэсэн Аж үйлдвэрийн яамны тушаалыг эсэргүүцэн ажил хаялт зохион байгуулжээ.

Эх сурвалж: The Wire, Amnesty International. 2004 оны 5-р сар, дугаар 34, №04.

Дээрх баримтаас үзэхэд Монголд ҮЭ-ийн гишүүд эрх мэдэлтэн, албан тушаалтнуудад таалагдахын тулд тэдний шударга бус үйлдэл, үйл ажиллагаатай эвлэрэнгүй хандах болжээ. Энэ байдалд олон хүчин зүйл нөлөөлж байгаа боловч хамгийн ихээр нөлөөлж буй хүчин зүйл нь бусдаас дэмжлэг авч чаддаггүй байдлаас болж бүлгийн дарамт шахалтанд өртөх явдал юм. Хэдий тийм боловч энэ нь нэг удаагийн судалгааны үр дүнд тулгуурласан тайлбарлал бөгөөд цаашид энэ асуудлыг нарийвчлан судлах хэрэгтэй юм.

3.4 Хуульч, өмгөөлөгчдөд тулгардаг бэрхшээл

Хүний эрхийг хамгаалахад эрх зүйн хүрээнд оролцон ажилладаг мэргэжлийн өвөрмөц онцлог бүхий хуульч, өмгөөлөгчдийн фокус бүлгийн гишүүд тулгарч буй бэрхшээлийг хэрхэн үзсэнийг энэ хэсэгт нарийвчлан авч үзэв.

Дараах хүснэгтэнд бүлгийн гишүүдийн эрэмбэлсэн дарааллаар бэрхшээлүүдийг багцлан илэрхийлэв. Судалгаанд 26 төлөөлөл оролцсон 3 фокус бүлгийг зохион байгуулсан болно. Энэ төлөөлөлд шүүгч болон

өмгөөлөгч мэргэжилтэй эмэгтэйчүүд, хуулийн чиглэлээр суралцдаг оюутнууд хамрагдсан.

Хүснэгт 4. Хуульч эмэгтэйчүүдэд тулгардаг бэрхшээл /эрэмбээр/

Эрэмбэ	Тулгардаг бэрхшээл
I	Хуульчдын аюулгүй байдлын баталгаа хангагдаагүй, эрх зүйн зохицуулалт сул байгаа явдал,
II	Хамгаалуулагч туслалцаа хүсэгчдийн эрх зүйн мэдлэг дутмаг байх
III	Хуулийг зориуд завхруулдаг, төрийн байгууллагын ажилтны ёс зүй, хүнд суртал, үл тоомсорлох, хээл хахуульд өртдөг байдал
IV	Мэдээлэл олж авах бололцоо хязгаарлагдмал тэгш бус байдаг, цаг хугацаа алдах
V	Заналхийлэх, байнга сэтгэл зүйн дарамтанд байх, айлган сүрдүүлэх, эрхшээлдээ оруулах явдал
VI	Шашны зан үйл ашиглан сэтгэл зүйн дарамт үзүүлэх явдал

Фокус бүлгийн гишүүдийн хувьд хамгийн их бэрхшээл учруулдаг зүйл нь хуульчдийн /шүүгч, өмгөөлөгч, хуулийн байгууллагын бусад ажилтнууд/ аюулгүй байдлын баталгааг эрх зүйн хүрээнд төдийгүй бодит байдал дээр хангаж чадаагүйтэй холбоотой. Хэдийгээр хуулийн зарим тодорхой заалтууд байдаг ч хэрэгжилтийн байдал нь анхаарал татаж байна. Шүүгчдийн хувьд хуулийн тодорхой заалтуудаар хамгаалагдах эрх зүйн орчин бий боловч тэр нь дорвитой хамгаалалт болж чадахааргүй байна.



Судлаачид Фокус бүлгийн гишүүдийн дунд асуудлыг хэлэлцүүлж буй байдал /2004 оны 11-р сар/

Харин өмгөөлөгчдийн хувьд “. . . ерөнхий хуулийн заалтууд байдгаас бус тодорхой, нарийн тусгасан хамгаалах эрх зүйн механизм үгүйлэгдэж байна” гэж фокус бүлгийн гишүүд үзэж байв.

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг байх явдал ч хуульчдад тулгардаг бэрхшээлүүдийн нэг болохыг бүлгийн гишүүд мөн тодорхойлж байлаа. Өмнөх бүлгүүд ч мөн адил энэхүү байдал тэдний үйл ажиллагаанд ихээхэн бэрхшээл учруулдаг зүйл болохыг илэрхийлж байсан юм. Үүнээс үзэхэд иргэн хүний эрх зүйн мэдлэг дутмаг байх явдал нь хувь хүнд төдийгүй, хүний эрхийг хамгаалагчдад сөргөөр нөлөөлдөг хүчин зүйл болно. Нэг талаас эрх зүйн мэдлэг дутмаг байх явдал нь хүний эрхийн зөрчил даамжирах

бололцоог төрүүлдэг байж болох юм. Харин нөгөө талаас хувь хүний эдийн засгийн аюулгүйн баталгаа хангагдаагүй нөхцөлд тухайн хүний бусад эрх, эрх чөлөөг бодитоор хамгаалахад бэрхшээлтэй байдаг.

Баримт 4. Нэгэн шүүхийн шүүгч О-той ярилцсан ярилцлага

. . . Хүний эрхийг хамгаалах гэдгийг зарим хүмүүс сайн ойлгодоггүй. Тэдний хуулийн мэдлэг муу байдаг. Хэрвээ шүүхийн шийдвэр нөгөө хүнд тааламжгүй гарвал хэргийг буруу шийдсэн гэж ойлгож сөрөг хандлага гаргадаг. Иргэний хэрэг дээр асуудлыг шийдвэрлэхэд маш хүнд, танил талаа харлаа, буруу шийдлээ гэх мэтээр гүтгэж дарамт үзүүлэх мөн сахилгын хороонд гомдол мэдүүлэх явдал гардаг.

. . . Шүүгчдийг хамгаалсан эрх зүйн нарийн тогтолцоо манайд байхгүй. Харин ч шийтгэх талаар заасан заалтууд их байдаг. Өөрийн эрх зөрчигдсэн талаар цаг зав гарган хөөцөлдөх боломж багатайгаас тэр бүр эрхийн зөрчлөө шийдүүлж чаддаггүй.

Эх сурвалж: Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл:

Хүний эрхийг хамгаалахад төрийн нэрийн өмнөөс тодорхой үүрэг хүлээн ажилладаг хүчний байгууллагын албан тушаалтан өмгөөлөгчдийн хооронд үүсдэг бэрхшээл, хүндрэл нь хөндөгдөж байгаа гурав дахь том сэдэв болж байна.

Ихэнх тохиолдолд шүүн таслах ажиллагаанд өмгөөлөгчийн оролцоо хязгаарлагдмал шинжтэй, мэдээлэл авах боломж тэгш бус байдаг нь ихээхэн хүндрэлтэй асуудал болохыг фокус бүлгийн гишүүд дурьдаж байв.

Шигтгээ 7.

. . . Хуульд шүүн таслах ажиллагаа нь эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана гэж тодорхой заасан /хуулийн 17-р зүйл/ байдаг. . . . Гэвч энэ тэгш эрх нь зөвхөн шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий асуудлаар саналаа илэрхийлэхтэй л холбоотой байна.

. . . Шүүх хуралдаанаас өмнө дан ганц яллах талын санаачлага, оролцоогоор цуглуулсан нотлох баримтыг шинжлэхэд л санал өгөхөөр хязгаарлагдаж буй учраас өмгөөлөх талын хувьд ихээхэн учир дутагдалтай “эрх тэгш” байдал юм. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нотлох баримт цуглуулахад өмгөөллийн тал ямар эрхтэй байх нь байцаан шийтгэх ажиллагааг шударга, үнэн зөв явуулахад шийдвэрлэх ач холбогдолтой.

Эх сурвалж: ХЭҮК, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, УБ 2003. хуудас [49-50]

Түүнчлэн албан тушаалтнуудын /шүүгч, прокурор, цагдаа гэх мэт/ хүнд суртал⁹, ёс зүйн доголдол, хариуцлагатай холбогдсон асуудал нь бас нэг томоохон бэрхшээлийг бий болгож байна.

Тухайлбал “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийг чирэгдүүлэх, хүнд суртал гаргах, хэрэг маргааныг шийдвэрлэхгүй удаах явдал их байдаг гэдэгтэй санал нийлэх үү? гэсэн асуултанд судалгаанд оролцсон хуульчдын 68.2% нь, иргэдийн 49.9% нь **үнэхээр хүнд суртал гаргаж хүмүүсийг залхтал чирэгдүүлдэг**” гэж хариулжээ.

Судалгаанд оролцогсдын 33.3-48.1 хувь нь “шүүгч, прокурор, цагдаагийн ажилтнууд танил тал, найз нөхөддөө илүү үйлчилдэг, асуудалд хэт нэг талыг барьдаг, оролцогч талуудаас бэлэг сэлт авдаг” гэж хариулсан ба судалгаанд хамрагдсан хуульчдын 55.3% нь, иргэдийн 73.8% нь хуулийн байгууллагын ажилтнууд хээл хахууль, авилга авдаг гэдэгтэй санал нийлдгээ илэрхийлжээ /Хүний эрхийн боловсролын төвийн хийсэн “Хуулийн байгууллагуудын ил тод нээлттэй байдлыг хангах асуудал” сэдэвт судалгааны тайлан/.¹⁰

Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны “Авилгалын эдийн засгийн өртөг” судалгааны тайланд: “. . . Нийслэлийн шүүх 1999 онд хээл хахуулийн 7 хэрэгт 25 шүүгдэгч 2000 онд 3 хэрэгт 9 хүн бүгд 10 хэрэгт 34 шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ. Судалгаанд оролцогсдын 40.98 хувь нь шүүгч авилгал авдаг гэж үзсэн байна. Манай хууль хяналтын байгууллага шүүгч нар авилгалд өртсөн байдлаараа 3-рт орж байна” гэж дурьджээ.¹¹

УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдан үйл ажиллагаа явуулсан 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хойш энэ оны эхний хоёр сар хүртэлх 5 сарын хугацаанд нийтдээ цагдаагийн ажилтнуудтай холбоотой 222 эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, прокурорын хяналтанд шилжүүлжээ [Авилгалын эсрэг үндэсний бага хуралд тавигдсан илтгэл, 2003-03-27].¹²

Энэ мэт жишээ баримтаас үзэхэд хүний эрхийн зөрчил гарахад хуулийг сахиулах үүрэгтэй төрийн хүчний байгууллагын албан тушаалтнуудын зүгээс ихээр нөлөө үзүүлэх болсон нь ноцтой асуудал болно. Тэгш бус харилцаанд хүний эрхийг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд хөндлөнгийн зүгээс оролцож байгаа өмгөөлөгчдөд энэ нь ихээхэн сөрөг

⁹ **Тайлбар:** Хүнд суртал – [Bureaucrasy] гэдэг ойлголтыг онолын тайлбарлалаар бус олон нийтийн ойлголтоор чирэгдүүлэх, хүлээлгэх, албан тушаалтан өөрийн үүргээ биелүүлэхгүй байх, хууль журмыг гажуудуулах байдалыг томъёолж илэрхийлсэн болно.

¹⁰ ХЭҮК, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, УБ 2003. хуудас [40]

¹¹ Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр, Үндэсний шударга ёсны тогтолцоо түүний үзүүлэлтүүд, УБ 2003. хуудас [192]

¹² ХЭҮК, Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, УБ 2003. хуудас [44]

хандлага үзүүлж байна. Энэ нь магадгүй маргалдагч эсрэг тал, албан тушаалтны зүгээс дарамт үзүүлэх, заналхийлэх, нэр төрд нь халдах, биед нь гэмтэл учруулах хэмжээнд хүртэл олон арга замаар илэрч байгааг судалгаанд оролцсон өмгөөлөгч эмэгтэйчүүдийн фокус бүлгийн гишүүд онцлон тэмдэглэж байсан юм.

Түүнчлэн үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг хамгаалж шүүн таслах ажиллагаанд оролцож байсан өмгөөлөгчийг хуулийн хариуцлагад татаж хаалттай шүүх хурлаар ялласан явдал нь /шоронд хорьсон/ хүнд хэлбэрийн сөрөг нөлөөллийн илрэл гэж үзэж болно. Хэдийгээр яллах эрх зүйн үндэслэл байгаа гэх боловч энэ үндэслэл өнөөг хүртэл тодорхой бус нууцын зэрэглэлд байсаар байна.

Сөрөг хандлагын бас нэг илрэх хэлбэр нь шашны ямарваа нэг зан үйл ашиглах /элс, будаа зэрэг зүйлс цацах, хараал хийлгэх, ном уншуулах гэх мэт/ явдал нь шүүгч, өмгөөлөгчдийн хувьд сэтгэл зүйн дарамт үүсэх шалтгаан болдог талаар бүлгийн гишүүд өгүүлж байлаа. Энэ нь ихээхэн онцлог шинжтэй учирч буй бэрхшээл юм.

Бүхэлд нь багцлан авч үзвэл хүний эрхийг хамгаалагчдад дараах нийтлэг бэрхшээл тохиолдож байна. Үүнд:

- Иргэдийн, эрхээ хамгаалуулагчдын хууль эрх зүйн боловсрол дутмаг, эрхээ хамгаалах идэвх оролцоо сул байгаа байдал,
- Албан тушаалтнуудын зүгээс хуулийг зөрчих, гуйвуулах улмаар хүний эрхийн зөрчил гаргах явдал түгээмэл шинжтэй болсон явдал,
- Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчин хангалттай хэмжээнд төлөвшиж чадаагүй байдал,
- Эдийн засаг, нийгмийн төдийгүй аюулгүй байдлын баталгааг хангах бололцоо бүрдээгүйгээс хамгаалалтын механизм эмзэг шинжтэй байна гэж үзэж болох юм.

Хэдийгээр хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тогтолцоо бүрдэж чадаагүй боловч хүний эрхийг хамгаалагчид өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалахын тулд идэвхитэй оролцох, нэгдэх шаардлагатай. Үүнээс ч их зүйлийг эрх зүй, нийгэм, эдийн засгийн хүрээнд хийх, иргэдийн эрх зүйн боловсрол, идэвхийг дэмжих нь чухал болоод байна.

Бүлэг 4. Бэрхшээлийг шийдвэрлэх боломж, арга зам

Өмнө өгүүлсэн бүхий л бэрхшээл, сөрөг хандлагуудыг шийдвэрлэх ямар боломж, арга зам байж болох талаар судалгаанд оролцогсад хэрхэн үзэж байгаа талаар судалгааны үр дүнд тулгуурлан энэ бүлэгт авч үзэх болно.



Судлаачид Фокус бүлгийн гишүүдийн дунд асуудлыг хэлэлцүүлж буй байдал /2004 оны 11-р сар/

Судалгаанд оролцогсад өмнө өгүүлсэн бэрхшээлүүдийг дараах байдлаар шийдвэрлэх боломжтой талаар өөрсдийн саналыг илэрхийлж байсан бөгөөд тэдгээр саналуудыг аль болох багцлан илэрхийлэхийг зорьсон болно. Фокус бүлгийн гишүүд /Хүний эрхийн ТББ-ын ажилтан, ҮЭ-ийн гишүүд, хуульч эмэгтэйчүүдийн/ өөр хоорондоо ялгаатай байдлаар хандаж байсан боловч тэдгээрт бас нийтлэг шинж

ажиглагдаж байв.

Харин одоо бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх боломж, арга зам байж болох талаар өгүүлсэн Фокус бүлгийн гишүүдийн саналыг авч үзье.

4.1 Хүний эрхийн ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг

Хүний эрхийн ТББ-ын ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлгийн гишүүд тэдэнд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд хамгийн түрүүнд дараах асуудалд анхаарал хандуулж шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байв. Үүнд:

- Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх /ТББ-ын тухай хуулинд хамгаалалтын талаар заалт оруулах хэрэгтэй/,
- Хүний эрхийн ТББ-ыг Омбудсман маягаар ажиллуулах, дэмжлэг үзүүлэх механизм бий болгох,
- Альч түвшинд хүний эрхийн боловсролыг системтэй олгох /албан тушаалтан, иргэд, өсвөр үеийнхэнд/,

- Хүний эрхийн ТББ-ын ажилтнуудын нийгмийн хамгаалал, халамжийн асуудлыг шийдэх, хөнгөлөлт урамшуулал үзүүлэх,

Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудал нь мэдээж хэрэг чухал хүчин зүйл болно, ТББ-ын тухай хуульд бус харин тусгайлсан хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай хуулинд энэ чиглэлийн харилцааг зохицуулах, хамгаалалтын талаар заалт оруулах нь зүйтэй.

Хүний эрхийн ТББ-ыг нэгтгэж үйл ажиллагааг нь уялдуулсан, дэмжлэг үзүүлэхүйц эвсэл, сүлжээ зэргийг байгуулан ажиллах, хүний эрхийн ТББ-ыг хүний эрхийн омбудсман хэлбэрээр ажиллуулах боломжийг судалж үзэх хэрэгтэй. ХЭҮК-оос хүний эрхийн ТББ-тай бүх хэлбэрээр хамтран ажиллах, орон нутаг дахь салбаруудыг нь татан оролцуулах, “хүний эрхийн итгэмжлэгдсэн төлөөлөгч” болгох зэргээр үйл ажиллагаагаа илүү ойртуулах талаар тодорхой ажлууд хийж болох юм.

Хүний эрхийн боловсролыг олгох чиглэлд ХЭҮК болон бусад хүний эрхийн ТББ-ын үйл ажиллагааны тайлан, илтгэлд хийсэн ажлууд хүрсэн үр дүнг тодорхой дурьдсан байдаг. Магадгүй эдгээр нь тоо баримт, зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр илүүтэй илэрхийлэгдэж байж болно. Үйл ажиллагаанд тавих шалгуур үнэлгээний механизмыг чухалчилан үзэж мониторинг үнэлгээ хийн чанарын талыг тодруулах нь зүйтэй юм. Өнөөдрийг хүртэл хийсэн, хүрсэн үр дүнгээс ч илүү их зүйлийг хийх шаардлага байсаар байна. Иргэд, албан тушаалтнуудын хүний эрхийн талаарх ойлголтын түвшин төдийлөн сайжирсан тодорхой илрэл харагдахгүй байсаар байна.

Нийгмийн хамгаалал, эдийн засгийн баталгааг бий болгоход тодорхой бодлого баримталж, эрх зүйн орчноор хамгаалахад төр, ТББ-ын удирдлага оролцогч талууд анхаарч үзэх хэрэгтэй болоод байна. Магадгүй хувь хүнийг идэвхижүүлэх, дэмжих чиглэлийн ажлууд байж болох юм.

4.2 ҮЭ-ийн ажилтан эмэгтэйчүүдийн Фокус бүлэг

Фокус бүлгийн гишүүд бэрхшээлийг шийдвэрлэх боломж, арга замуудыг дараах байдлаар үзэж байв. Үүнд:

- ҮЭ-ийн ажилтны эрхийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгтэй,
- Хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, алагчлалгүй хандах хэрэгтэй /шүүх мөнгөтэй хүнд илүү үйлчилж байгаа байдлыг зогсоох/,

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан олон нийтэд баримттай мэдээлж байх,
- ҮЭ-ийн ажилтнуудыг чадавхижуулах хэрэгтэй,

Албан тушаалтнуудын хууль бус үйлдэлтэй тэмцэхэд шүүхийн тогтолцоо ялангуяа захиргааны хэргийн шүүхийн үүрэг, ач холбогдол чухал юм. ҮЭ-ийн гишүүдэд захиргааны албан тушаалтнуудын үзүүлдэг сөрөг нөлөөг /ҮЭ-ийн удирдах албан тушаалтан, байгууллагын дарга гэх мэт/ бууруулахад онцгой анхаарах хэрэгтэй байна. Магадгүй ҮЭ-ийн гишүүд “ажлын байраа алдах” гэсэн сэтгэл зүйн дарамт, хүлээст автах бус харин ч эрх нь зөрчигдөж буй аливаа тохиолдолд албан тушаалтнуудыг хариуцлагад татах, эрх ашгаа хамгаалахаар хамтран тэмцэх чадавхи, мэдлэг, итгэл үнэмшилтэй болох нь чухал болоод байна.

Энэ үйл явц мэдээж хэрэг нарийн түвэгтэй, бэрхшээлтэй боловч хүлцэнгүй байдлаар асуудалд хандах нь мэдээж хэрэг сайн үр дүн авчирахгүй. Иймээс ҮЭ-ийн гишүүдийг чадваржуулахад анхаарах хэрэгтэй. Аливаа хөдөлмөрийн харилцаанд гарч буй зөрчил, хууль бус шийдвэр, эрх ашиг хөндсөн асуудалтай хамтарч тэмцэх, эрх ашгаа илэрхийлэх нь эвлэрч хандсанаас илүүтэй үр дүн, урам зориг төрүүлэх болно.

ҮЭ-ийн гишүүдийн эрхийг хамгаалсан эрх зүйн орчинг мөн адил тусгайлсан хуулиар ерөнхийд нь эсвэл тухайн салбарын хуулиар нарийвчлан зохицуулж болох юм. Энэ чиглэлд хийх зүйл чамгүй их байна.

4.3 Хуульч, өмгөөлөгч эмэгтэйчүүдийн Фокус бүлэг

Бүлгийн гишүүд өөрсдөд нь тулгарч байгаа бэрхшээлийг дараах байдлаар шийдвэрлэх боломж, арга зам байж болно гэж үзсэн бөгөөд тэдгээр саналуудыг багцлан илэрхийлэв. Үүнд:

- Эрхийг хамгаалах тусгайлсан хууль эрх зүйн орчинг бий болгох /одоогийн хууль эрх зүйн орчинд ерөнхий нэг заалт байдаг учир хамгаалалт болж чаддаггүй/,
- Хуульчдийг сэтгэл зүйн болоод эдийн засгийн дарамтгүй байх баталгааг хангах, хамгаалалтын механизмыг бодитой болгох /эдийн засаг нийгэм, аюулгүй байдлын баталгааг хангах хэрэгтэй/,
- Хууль, хуулийн заалтуудыг биелүүлдэг болох, хуулийн тайлбаруудыг зөрчилгүй байлгах /хуульчид өөр өөрсдийнхөөрөө

тайлбарлах, өөрсөддөө ашигтай байдлаар ойлгох явдал нийтлэг байна/,

- Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг сайжруулах, тэднийг чадавхижуулах /ухуулга, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрчимтэй явуулах хэрэгтэй/,

Ханнс Зайделийн сангаас иргэдэд “Эрх зүйн боловсрол” олгох, дэмжих чиглэлээр телевизийн сувгийг ашиглан олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаа нь сайшаалтай. Ийм маягаар иргэдэд шүүх тогтолцоо, эрх зүйн үйл явцын талаар, хүний эрхийн талаар хялбаршуулсан байдлаар мэдлэг олгох нь эрхээ хамгаалахад оролцох чухал нөлөө болно. Үүний нэгэн адил төрийн захиргаа, орон нутгийн удирдлага, төрийн захиргааны албан хаагчдын талаар мөн төрийн бус байгууллага, хүний эрхийн байгууллагууд, хүний эрхийн зөрчил, түүнийг хамгаалах талаар мэдээлэл түгээх, мэдлэг олгох нь иргэд эрхээ хамгаалахаар нэгдэх, албан тушаалтнаас шаардах эхний алхам болно.

Эдгээр үйл ажиллагаа нь иргэний нийгмийн үндэс суурь болсон иргэдийг чадавхижуулах, иргэн хүн байхад нөлөөлж буй үйл явц бөгөөд улмаар иргэд шаардлагатай, хариуцлагатай хандах болсноор төрийн институц жинхэнэ утгаар иргэдэд үйлчилэх, шударга ялгаварлалгүй хандах боломж бүрдэх болно. Мэдээж хэрэг дан ганц иргэд бус хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох нь чухал. Тэрхүү тогтолцоо нь хүний эрхийг хамгаалагчид /иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд, хууль эрх зүйн орчин, шударга шүүх/ байх болно.

Шударга ялгаварлалгүй шүүхийг бий болгох, шүүгчдийн хараат бус байдлыг баталгаатай хангах нь зайлшгүй шийдвэрлэх ёстой зүйл гэж Фокус бүлгийн гишүүд үзэж байв. Үүнд хуульчдын /шүүгч, өмгөөлөгч, прокурор гэх мэт/ эдийн засгийн болоод нийгмийн баталгаа, аюулгүй байдлын баталгааг хэрхэн хангах талаар төрөөс тодорхой бодлого баримтлах, бодитой зүйл хийх хэрэгтэй болоод байна. Мөн хуулийн тодорхой заалтуудыг боловсронгуй болгох /ялангуяа өмгөөлөгчид шүүх хуралдаанд ялагч талтай эн тэнцүү эрхтэй оролцдог байх/ шаардлагатай юм.

Үүний зэрэгцээ хүний эрхийг хамгаалахад оролцож байгаа хуульчдын эрхийг хамгаалахад чиглэгдсэн тусгайлсан хууль эрх зүйн орчин зайлшгүй чухал болохыг бүлгийн гишүүд онцлон тэмдэглэж байв. Гэхдээ энэхүү хууль эрх зүйн орчин цаасан дээр бус бодит амьдрал дээр бий болох нь чухал.

Дүгнэлт, бодлогын зөвлөмж

Монголд хүний эрхийг хамгаалагчдад тулгарч буй бодит бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замыг тодруулах зорилго бүхий “Монголд хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүдийг хамгаалах боломж” сэдэвт судалгааны ажлыг Улаанбаатар хот, төвийн бүсийн орон нутагт Фокус бүлэг, ганцаарчилсан сурвалжлагын аргуудаар явуулж судалгааны үр дүнг нэгтгэн тайлагнаж байна.

Судалгааны сэдэв шинэлэг бөгөөд урьд өмнө төдийлөн судлагдаж байгаагүйгээрээ ихээхэн онцлогтой байв. Мөн судалгаанд баримталсан арга зүй, аргачлал нь чанарын судалгааны аргууд байлаа.

Судалгааны үр дүнд хүний эрхийг хамгаалагчдад тулгарч буй хамгийн том бэрхшээл нь тэднийг хамгаалах хууль, эрх зүйн тодорхой орчин байхгүй байгаа явдал гэж дүгнэж болно. Одоогийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчин нь хүний эрхийг хамгаалагчдыг ялангуяа хүний эрхийн ТББ-ын ажилтан, ҮЭ-ийн гишүүд, хуульч, өмгөөлөгчдийг хамгаалах бодитой хамгаалалт болж чадахгүй байна. Иймээс тусгайлсан хуулийг батлах, энэхүү харилцааг онцгойлон авч үзэх шаардлагатай байгаа юм.

Мэдээж хэрэг хүний эрхийг зөрчсөн аливаа тохиолдолд эрх зүйн хариуцлага хүлээх боловч хүний эрхийг хамгаалсныхаа төлөө ямар нэг байдлаар тухайн хүний эрх нь зөрчигдөж байгаа тохиолдолд түүнийг онцгойлон авч үзэн тусгайлсан хууль эрх зүйн орчноор зохицуулах нь зохимжтой. Хуульд өмгөөлөгчид, ҮЭ-ийн гишүүд, хүний эрхийн ТББ-ын ажилтан, хүний эрхийн ажилтан, сэтгүүлчид зэрэг хүмүүсийг хэрхэн эрх зүйн орчноор хамгаалах талаар тусгаж болох юм.

Иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсрол хангалтгүй байгаагаас тэд зөрчигдсэн эрхээ хамгаалах нь битгий хэл зарим тохиолдолд хүний эрхийг хамгаалагчдад бэрхшээл учруулахад хүрдэг талаар судалгаанд оролцогсод дурьдаж байв. Нөгөө талаас иргэдийн эрх зүйн ойлголт төлөвшихөд олон нийтийн дунд байгаа тогтсон хандлага хүчтэй нөлөөлж байна. Энэ нь “мөнгөтэй хүн өөрт ашигтай шийдвэрийг гаргуулдаг, шүүх, албан тушаалтнууд хамгийн их хахууль авдаг, шударга бус” гэж үзэх үзэл, шүүх тогтолцоо, засаг захиргааны үйл ажиллагаанд байгаа хүнд суртал, чирэгдлээс үүдэлтэй танил тал, арын хаалгыг эрхэмлэх болсонтой холбоотой юм. Магадгүй олон нийтэд ийм ойлголт төлөвшихөд шүүх болон засаг захиргааны үйл ажиллагаа ч хүчтэй нөлөөлсөн нь ойлгомжтой.

Захиргааны үйл ажиллагааг иргэдэд ойртуулж тэдэнд үйлчилдэг болгох, шүүх тогтолцоог шударга байлгахад иргэдийн оролцоо, хяналтын систем чухал болоод байна. Үүний тулд иргэдийг чадваржуулах, мэдээллээр хангах, мэдлэг олгох хэрэгтэй гэж үзэж болно. Бүх хэлбэрийн нөлөөллийн арга хэрэгслийг ашиглан иргэдийн ойлголтыг төлөвшүүлэхэд анхаарах нь ихээхэн чухал тулгамдсан асуудал болоод байна.

Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахад тэдний эдийн засаг нийгмийн баталгааг хангах, аюулгүй байдлыг баталгаажуулах явдал чухлаар тавигдах боллоо. Шударга шүүхийн тогтолцоог бий болгохын тулд шударга хараат бус шүүгч, шүүхийн тогтолцоо, чухал юм. Хэдийгээр Үндсэн хуулиар шүүх засаглал хараат бус байна гэж хуульчилан тунхаглаж байгаа боловч бодит байдал дээр эдийн засаг, нийгмийн талаасаа тодорхой хүчний эрхшээлд орсон нь нийгмийн зүгээс үнэлж байгаа авилгалд их өртсөн, шударга бус шийдвэр гаргадаг гэсэн үнэлэмжээр баталгаажиг байна.

Судалгааны үр дүнгээр хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах бодитой алхам нь тэдний эдийн засаг, нийгмийн баталгаа, аюулгүй байдлыг хангах явдал гэж үзэж болно.

Хэдийгээр сэтгүүлчдийг энэхүү судалгаанд хамруулаагүй боловч хүний эрхийг хамгаалахад идэвхитэй оролцдог субъект болохын хувьд хамгааллын үйл ажиллагаанд тэднийг зайлшгүй оруулах хэрэгтэй юм.

Багцлан авч үзвэл Монголд хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах боломж эрх зүйн хувьд хангалттай хөгжиж чадаагүй байгаагаас гадна тэдний эдийн засгийн болон нийгмийн цаашлаад аюулгүй байдлын баталгаа хангагдаагүй байгаа явдал нь энэ чиглэлд их зүйл хийх ёстойг илтгэж байна. Монголд хүний эрхийг хамгаалагчдын эрхийг зөрчих явдал далд хэлбэртэй, нийтлэг шинжтэй байна гэж үзэж болно. Ялангуяа өмгөөлөгчид, сэтгүүлчдийн эрхэнд халдах, үндэслэлгүй ял тулгах, хорих, саатуулах, дарамт үзүүлэх, заналхийлэх явдал байсаар байна.

Хамгийн ноцтой нь олон нийтийн дунд тогтсон сөрөг хандлага, ойлголт нийгмийн зүгээс үзүүлж буй томоохон дарамт болж байна. Эрхээ хамгаалахаар хамтрах, нэгдэх явдал хангалтгүй байгаагаас төдийлөн үр дүнтэй бус байх, шантрах, хүч мөхөсдөх явдал байсаар байна.

Эцэст нь судалгааны үр дүн, дүгнэлтүүдэд тулгуурлан дараах бодлогын зөвлөмжүүдийг өгч байна. Энэ нь хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахад юунд илүүтэй анхаарах, ажлаа юунаас эхлэхэд хэн бүхэнд

санаа өгөхөд чиглэгдсэн болохоос бус зайлшгүй тийм байх ёстой гэсэн үг биш юм.

Нэгтгэн авч үзвэл дараах арга замууд байж болно:

1. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тусгайлсан хууль эрх зүйн орчинг бий болгох хэрэгтэй. Хуульд хамгаалалтын тогтолцоог нарийвчлан зааж өгөх нь зүйтэй. Үүний тулд эрх бүхий байгууллагад нөлөөлөх, хууль санаачилах байдлаар оролцогч талуудын оролцоог хангасан, саналыг тусгасан байх нь зүйтэй. Энэ үйл явцад ХЭҮК тэргүүлэх үүрэгтэй оролцож бусад төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах нь чухал болоод байна.
2. Хүний эрхийг хамгаалагчдын эдийн засаг, нийгмийн баталгааг хангахад төрийн зүгээс тодорхой бодлого баримтлах ёстой. Энэ нь нэг талаар хамгаалалт болох болно. Ялангуяа хуульчдын баталгаа, шүүх тогтолцооны хараат бус байдлыг дээшлүүлэх талаар бодитой ажлууд хийж, үр дүнд хүрэх нь чухал болоод байна. Үүнд төр голлох үүрэгтэй оролцохоос гадна хуульчид ёс зүйн болон хариуцлагын хувьд дээшилж, чадваржих нь чухал.
3. Хүний эрхийн боловсролыг бүх нийтэд олгох тогтолцоог бий болгох хэрэгтэй. Иргэд шаардлагатай, идэвхитэй оролцоотой, үзэл бодлоо илэрхийлж байх нь эрхээ хамгаалах гол нөхцөл бөгөөд үүнийг хүний эрх, эрх зүйн боловсролоор олж авдаг. Үүний тулд иргэдэд эрх зүйн боловсролыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ойлгомжтой байдлаар түгээж болно. Дунд сургуульд энэ чиглэлээр тодорхой сэдэв, агуулга бүхий хичээлийн хөтөлбөр бий болгож болох юм. Мөн албан тушаалтнуудын хүний эрх, эрх зүйн боловсрол, хариуцлагыг дээшлүүлэхэд тодорхой алхамууд хийж байгаа ч үүнээс ихийг хийх хэрэгтэй байна.

Энэ бүхэн нь иргэний нийгмийг төлөвшүүлэх, ардчилсан засаглалыг төгөлдөржүүлэхэд чухал нөлөө үзүүлэхүйц суурь хүчин зүйлс билээ.

Хавсралтууд

Хавсралт А. Урьдчилсан судалгаанд уулзалт зохион байгуулсан Төрийн болон ТББ-ын жагсаалт

№	Байгууллагууд
1	Зохистой Хөгжлийн Жендер Төв
2	Зориг Сан
3	Либериаал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан
4	Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо
5	Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо
6	Монголын Өмгөөлөгчдийн Холбоо
7	Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо
8	Монголын Эмэгтэйчүүдийн ТББ-уудын Эвсэл
9	Монголын Ардчилсан Социалист Эмэгтэйчүүдийн Холбоо
10	Монголын Эмэгтэйчүүдийн Сан
11	Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн
12	Хүний Эрхийн Үндэсний Комисс
13	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв
14	CEDAW Watch Төв

Хавсралт В. Фокус бүлэг, ганцаарчилсан сурвалжлагын аргаар судалгаа явуулах арга зүйн удирдамж

Фокус бүлгийн хэлэлцүүлгийн явцад анхаарах зүйл:

- Бүлгийн хэн нэг гишүүн хэлэлцүүлэгт давамгайлан оролцох бусад гишүүдийн оролцоог хязгаарлахаас сэргийлэх,
- Бүлгийн гишүүд хэлэлцүүлэгт идэвхгүй оролцох, оролцохгүй байх, санал бодлоо дутуу илэрхийлэх тохиолдолд судлаач тухайн хүмүүсийг идэвхижүүлэх, өдөөх, энгийн асуулт тавих,
- Бүлгийн гишүүдийн харилцан санал бодол солилцох, хэлэлцэх үйл явц нь маргаан мэтгэлцээнд шилжих, үл ойлголцох байдалд хүрэхээс зайлсхийж энэ байдлыг таслан зогсоох,
- Хэлэлцүүлгийн явцад бүлгийн гишүүдээс гарсан санаа бодлыг шүүмжлэх, санал нийлэхгүй байгаагаа илт мэдэх нь зохимжгүй бөгөөд аль болохоор тэдний яриаг сонсож, хүндэтгэлтэй хандах,
- Урьдчилан бэлтгэсэн асуулт, хэлэлцэх сэдвээс ярилцлагын явцад нэмж тодруулах зүйлс гарсан тохиолдолд түүнийг лавлаж асуух,
- Хэлэлцэх сэдэв асуутуудыг сайн ойлгохгүй байгаа, болгоомжлон хандаж байгаа тохиолдолд тухайн асуултыг шууд тавилгүй тойруу замаар асуух, эсхүл нэг асуултыг олон янз байдлаар хэдэн ч удаа асууж болно.
- Бүлгийн хэлэлцүүлэг зохион явуулах байр, орчин нөхцөл нь бүлгийн гишүүдийг биеэ барих, эмээх, гадны нөлөөлөлд орохгүй байхад чухал байдаг учир орчноо сайн бүрдүүлж зохион байгуулах,

Фокус бүлгээр хэлэлцэх асуудал:

1. Хэлэлцүүлэг явагдах сэдэв, зорилгоо судлаач товч танилцуулах;
2. Бүлгийн гишүүдэд хандан өөрсдийгөө товч танилцуулахыг хүсэх;
3. Хүний эрхийг хамгаалах гэдгийг та хэрхэн ойлгож байна вэ? Хүний эрхийг хамгаалагч гэж хэнийг хэлэх вэ?

4. Хүний эрхийг хамгаалагчдад учирдаг ямар нэгэн хүндрэл бэрхшээл,
 - Бүлгийн гишүүдэд нэг ширхэг цаас А4 өгч тэрхүү цаасан дээр хүний эрхийг хамгаалагчдад учирдаг болон учирч болохуйц зүйлсийг жагсаан бичихийг хүн бүрээс хүсэж дунд нь аялуулна. Тухайн цаасан дээр өөрт төрж буй санаа бодлоо ямар нэг эргэцүүлэл шүүмжлэлгүйгээр буулгах хэрэгтэйг анхааруулж хэлнэ.
 - Эхний удаа цаасан дээр тэмдэглэсэн санааг дахин гишүүдийн дунд аялуулан өмнө тэмдэглэсэн санаа бодолд тулгуурлан өөр шинэ санаа төрсөн бол түүнийгээ бас тэмдэглэхийг хүсэх хэрэгтэй.
 - Цугларсан санаа, тэмдэглэлүүдийг одоо бүлгийн гишүүдийн дунд хэлэлцүүлж хамгийн их тохиолддог бэрхшээл хүндрэл аль болохыг ромбо тоогоор үнэлүүлж дараа нь энэ хүндрэл бэрхшээл ямар хүчин зүйлээс шалтгаалдаг талаар хэлэлцүүлэг өрнүүлэх хэрэгтэй.
5. Энэ бэрхшээл таньд болон танай байгууллагад учирч байсан уу? Таны ямар эрхийг хөндөж, зөрчиж байсан бэ?
6. Эмэгтэй хүн гэдгээс шалтгаалж хүний эрхийг хамгаалагчдад тулгардаг онцлог бэрхшээл байдаг уу?
7. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах шаардлага, нөхцөл боломж Монголд ямар байна гэж үздэг вэ?
8. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахын тулд эн тэргүүнд ямар зүйлийг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байна вэ?

Ганцаарчилсан сурвалжлагын үед ярилцах ерөнхий асуудал:

1. Судалгааны зорилгыг танилцуулах,
2. Овог нэр, албан тушаал,
3. Хэдэн жил энэ ажлыг эрхэлж байгаа, Цаашид ажлаа солих эсэх, тийм бол ямар шалтгаанаар,
4. Хүний эрхийг хамгаалах гэдгийг та хэрхэн ойлгож байна вэ? Хүний эрхийг хамгаалагч гэж хэнийг хэлэх вэ?
5. Хүний эрхийг хамгаалагчдад учирч болох хүндрэл бэрхшээл гэдэгт та юуг ойлгож байна вэ? Хэн нэгний эрхийг хамгаалсны төлөө таны эрх зөрчигдөж байсан уу?

6. Эмэгтэй хүн гэдгээс нь шалтгаалж хүний эрхийг хамгаалагчдад онцлог хүндрэл, бэрхшээл учирдаг уу? Хэрэв тийм бол тодорхой жишээ дурьдана уу?
7. Танд учирч байсан бэрхшээл, хүндрэлтэй зүйлс байгаа юу? Хэрэв тийм бол тодорхой жишээ дурьдана уу?
8. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах шаардлага, нөхцөл боломж Монголд ямар байна гэж та үздэг вэ?
9. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалахын тулд эн тэргүүнд ямар зүйлийг шийдвэрлэх хэрэгтэй гэж та үзэж байна вэ?

Хавсралт С. Судалгааны багийн гишүүд**Зөвлөх**

Ц. Пүрэв	ШУА-ийн Философи, Социологи эрхийн хүрээлэнгийн социологийн секторийн ахлах мэргэжилтэн
Б. Алтантуяа	Эмнести Интернэшнл байгууллагын Монгол дахь салбарын гүйцэтгэх захирал

Багийн ахлагч

О. Ууганбаяр	Судалгааны багийн ахлагч, судлаач
--------------	-----------------------------------

Судалгааны арга зүй, тайланг боловсруулсан

О. Ууганбаяр	Судалгааны багийн ахлагч, судлаач
Ц. Цэнд-Аюуш	Судалгааны багийн гишүүн, судлаач
О. Баяртуяа	Судалгааны багийн гишүүн, судлаач
Д. Оюунномин	Судалгааны багийн гишүүн, судлаач

Ашигласан материал

1. Amnesty International, 19 March 2004. Towards the Promotion and Protection of the Rights of Human Rights Defenders in Africa.
2. Amnesty International, 14 December 2004. China: Human rights defenders in China.
3. Amnesty International, 1 June 1999. More Protection, less persecution Human rights defenders in Latin America.
4. Виктор Конде, Лондон 1999. Хүний эрхийн олон улсын нэр томъёоны тайлбар толь.
5. Кит Гриффин. УБ 2001. Монгол дахь ядуурлыг бууруулах стратеги, НҮБХХ.
6. МУЗГ. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, Монгол улс 2003.
7. МУЗГ. НҮБХХ. Монголын хүний хөгжлийн илтгэл–2003.
8. МННХ, Глоб Интернэшнл ТББ. УБ 2003. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ.
9. MFOS, UB 2002. Acces to Justice; Access to a Free Legal Aid. Needs Assessment Report Mongolia.
10. Mongolia Country Gender Assessment. 9 May 2003. Mongolia.
11. С. Нарангэрэл, УБ 2001. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо
12. УТБА, УБ 1998 № 24. Шинэ толь сэтгүүл
13. ҮСГ. Монгол улсын статистикийн эмхтгэл *2003*, УБ 2004.
14. Томас Буергентал. УБ 2002. Олон улсын хүний эрх. МННХ.
15. ХЭҮК, УБ 2003. Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл.
16. ҮХЗХ, УБ 2001. Монгол улс дахь хүний эрхийн төлөв байдал.
17. Хүний Эрх, /улирал тутмын сэтгүүл/ УБ 2002 № 1.
18. Хүний Эрх, /улирал тутмын сэтгүүл/ УБ 2002 № 2.
19. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр, Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд, УБ 2003.
20. Эмнести Интернэшнл сонин бичиг, 2002/ 2003/ 2004 он
21. Эрх чөлөө төв ТББ, УБ 2003. Монгол улсын хуулийн байгууллага, хуульчдын лавлах товчоо.
22. Эмэгтэйчүүд, Хууль ба Олон Улсын Хөгжил, Вашингтон 1997. Эмэгтэйчүүдийн хүний эрх алхам алхмаар /гарын авлага/.